



# Зөвлөмжийн Цуврал

## ЗЦ139-14

Нэмэлт, өөрчлөлт 1 (1)

### Аэродромын Гэрчилгээжүүлэлт - Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө

2022 оны 12 сарын 9

#### Ерөнхий зүйл

ИНЕГ-ын зөвлөмжийн цуврал (АС) нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмуудын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргуудыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

#### Зорилго

Энэ АС нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид аэродромын онцгой нөхцөлийг төлөвлөхөд туслах зорилготой ИНД-139 “Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт”- ийн шаардлагад нийцсэн баримт бичиг юм. Энэ материал нь дараах хүсэлт гаргагч болон эзэмшигчид зориулагдсан.

- аэродромын гэрчилгээ
- хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ

Түүнчлэн, аэродромын гэрчилгээ эзэмшдэггүй үйл ажиллагаа эрхлэгчдэд мөн зориулагдсан болно.

#### Холбогдох дүрмүүд

Энэ АС нь ИНД-139-ийн шаардлагад хамаарах бөгөөд ялангуяа 139.57 Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө, ИНД-139.109 Эдгээр төлөвлөгөөний хэрэгжилт, ИНД-139.23 Хязгаарлагдмал аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийг тодорхойлох шаадлагат нийцсэн байна.

#### Өөрчлөлтийн бүртгэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

АС139-14-ийг монгол болон англи хэл дээр боловсруулсан бөгөөд хэрэв эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх хувилбарыг баримтална.

АС139-14-ийг NZ АС139-14-ийн 2015 оны 10 сарын 30-ны өөрчлөлт 1-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>1. ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>5</b>
1.1 Зорилго .....	5
<b>2. АЭРОДРОМЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>7</b>
2.1 Танилцуулга .....	7
2.2 Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөнд тавих шаардлага .....	7
2.3 Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний агуулга .....	7
2.4 Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлага .....	10
<b>3. АОНТ-НИЙ АШИГЛАЛТ .....</b>	<b>11</b>
<b>4. АОНТ-НИЙ УДИРДЛАГА .....</b>	<b>11</b>
4.1 Баримт бичгийн бүтэц .....	11
4.2 АОНТ-ний баримт бичгийн зохицуулалт .....	12
4.3 Төлөвлөгөөг хянах .....	12
4.4 Баримт бичгийн хяналт .....	12
<b>ХАВСРАЛТ А – АЭРОДРОМЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН ТӨРӨЛ.....</b>	<b>14</b>
A.1 Танилцуулга .....	14
A.2 Агаарын хөлгийн онцгой нөхцөл.....	14
A.3 Анхаарах асуудал.....	15
A.4 Аюулгүйн хамгаалалтын онцгой нөхцөл .....	16
A.5 Бусад онцгой нөхцөл .....	19
A.6 Дэмжих төлөвлөгөө.....	20
<b>ХАВСРАЛТ В - ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ БОЛОН ЗОХИЦУУЛАЛТ .....</b>	<b>24</b>
B.1 Холбооны хэрэгсэл .....	24
B.2 Холбооны систем.....	24
B.3 Жижиг аэродромыг анхаарах.....	29
B.4 Гуравдагч аэродром руу мэдээлэл өгөх .....	29
B.5 Зохицуулалт.....	29
<b>ХАВСРАЛТ С - ЭМНЭЛГИЙН АНХААРАХ ЗҮЙЛС .....</b>	<b>33</b>
C.1 Эмнэлгийн төхөөрөмж .....	33
C.2 Ангилах болон эмнэлгийн тусламж .....	33
C.3 Амьд үлдэгсдийг халамжлах .....	34
C.4 Амь үрэгдэгсдийн асуудлыг зохицуулах.....	35
<b>ХАВСРАЛТ D - БОДИТ НӨХЦӨЛД ОЙРТУУЛСАН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН ДАСГАЛ СУРГУУЛИЛТ</b>	<b>36</b>
D.1 Зорилго .....	36
D.2 Бодит нөхцөлд ойртуулсан онцгой нөхцөлийн дасгал сургуулилт .....	37
D.3 Дасгал сургуулилтын дараах тайлан.....	38
<b>ХАВСРАЛТ E - БУСАД АНХААРАХ АСУУДАЛ.....</b>	<b>40</b>
E.1 Угтагсад болон гашуудагсдыг зохицуулах.....	40
E.2 Терминалын зохион байгуулалт .....	41
E.3 Ослын талбай - нотлох баримтыг хамгаалах.....	41
E.4 Хэвийн үйл ажиллагаанд эргэж орох - сэргээх үе шат .....	42

---

Е.5	Бодит онцгой нөхцөлийн дараах тайлан.....	43
Е.6	АОНТ-ний тогтмол хяналт .....	44
<b>ХАВСРАЛТ F - ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ.....</b>		<b>45</b>
F.1	Баримт бичиг.....	45

## 1. Танилцуулга

ИНД-139-ийн дагуу аэродромын гэрчилгээ эзэмшигч нь аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө гаргах болон тогтмол шалгалтыг багтаасан онцгой нөхцөлийн төлөвлөгөөг байнга сайжруулах журамтай байх үүрэгтэй.

Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшигч нь нисэхийн судалгааны дараа ИНЕГ-ын Даргын гаргасан тодорхойлолтын дагуу аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө /АОНТ/-тэй байна. АОНТ шаардсан тодорхойлолт нь төлөвлөгөөнд байх бүх асуудлыг тусгах ба энэ нь гэрчилгээжсэн аэродромд тавих шаардлагат суурилсан байна. Эдгээр шаардлага нь аэродромын гэрчилгээ авахаас илүү төвөгтэй байж болохгүй.

АОНТ нь ICAO Annex 14, Vol I-Аэродромын Төлөвлөлт болон Үйл ажиллагааны шаардлагат суурилсан байна. Annex 14 нь АОНТ-г боловсруулахад шаардлагатай мэдээллийг өгнө.

“Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлт гэдэг нь аэродром дээр болон түүний орчимд онцгой нөхцөл үүссэн үед амжилттай давж гарах үүднээс холбогдох бэлтгэл ажлыг хийх ажиллагаа юм. АОНТ-г боловсруулах зорилго нь аюул, ослын үед гарах нөлөөллийг багасгах ялангуяа хүний амь аврах, нислэгийн үйл ажиллагааг үл тасалдуулах ач холбогдолтой. АОНТ нь ослын үед аэродромын орчим дахь байгууллагын туслалцаа, гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, зохицуулалтыг бий болгоно”.

Энэ АС-д сайтар төлөвлөсөн АОНТ-г гаргахын тулд аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон Онцгой Байдлын Хороо тусламж үзүүлэх аргачлал болон цаашдын анхаарах асуудлын эмхэтгэлийг үзүүлсэн болно.

Үүний зорилго нь иргэний нисэхийн орчин, өөр өөр зэрэглэл бүхий АОНТ-г гаргахад бий болох асуудлыг үзүүлэхэд оршино. АОНТ-ний хүрээ нь аэродром дээр явагдаж буй нислэгийн үйл ажиллагааны төрлөөс хамаарна. Энэ АС-ын зарим хэсэг заалт бүх аэродром дээр мөрдөгдөх боломжгүй байх талтай. АОНТ-г тухайн аэродромын үйл ажиллагааны зэрэглэл дээр тулгуурлан боловсруулна.

АОНТ-г ICAO Doc 9137-Нисэх буудлын үйлчилгээний гарын авлага, Хэсэг 7 - Нисэх буудлын АОНТ-г төлөвлөх нь мөн бусад иргэний нисэхийн АОНТ-г төлөвлөх журам, заавар, үйл ажиллагааны туршлага зэрэгт үндэслэн боловсруулна.

### 1.1 Зорилго

АОНТ нь аэродром дээр болон түүний орчимд онцгой нөхцөл үүссэн, эсхүл аэродромоос хол зайд гарсан агаарын хөлгийн ослын үед түүнийг амжилттай давж гарах холбогдох бэлтгэл ажлыг хийх юм.

Нисэх буудал орчмын газарзүйн байрлал болон ялангуяа аль хэсэг нь нисэх буудлын бүсэд хамаарах, аль хэсэг нь үл хамаарах алслагдсан бүс болохыг тодорхой заасан байх бөгөөд эдгээр бүсэд онцгой нөхцөлийн үед ямар статусаар ажиллахыг АОНТ-нд заасан байна. Гэхдээ баримт бичиг нь ямар нэгэн ослын тохиолдолд аэродромын байгууллагын АОНТ-ний зорилгод нийцсэн үнэлж баршгүй оролцоог хаах үтгэ санааг үл агуулсан байна.

Онцгой нөхцөл нь тухайн тохиолдолд болон дараа нь аэродромын үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлэх магадлалтай байдаг. АОНТ-ний зорилго нь ослын үед хүн гэмтэх, бэртэх нөлөөллийг мөн эд хөрөнгийн хохирлын хэмжээг бууруулах юм. Үүнд 2 үндсэн зүйл ордог.

Эхний зорилго нь хүний амь нас эрсдэх тохиолдлыг багасгах. Онцгой нөхцөл байдлаас шалтгаалсан шууд авах арга хэмжээ болон осолд шууд /хувь хүмүүсийн авах арга хэмжээ /эсхүл шууд бус /нисэх буудал доторх хүмүүс/ хамааралтай хүмүүсийг хамгаалах нь АОНТ-ний нэн тэргүүний зорилт байна.

Дараагийн зорилго нь аэродромыг аль болох түргэн хэвийн үйл ажиллагаанд эргүүлж оруулах. Тоног төхөөрөмжийн ажиллагаа, эд хөрөнгийг сэргээх, эсхүл тэдгээрийг ослын нөлөөллөөс хамгаалах нь онцгой нөхцөлийн дараа хэвийн үйл ажиллагаанд эргэж ороход маш чухал.

Аэродромын онцгой нөхцөлийн хариу арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан хэдий ч хэвийн үйл ажиллагаанд орно гэсэн үг биш учир нь аэродромын онцгой нөхцөлтэй холбоотой маш олон төрлийн хариу арга хэмжээ байсаар байна. Жнь: уулзагсад болон гашуудагсдад анхаарал тавих, авсан арга хэмжээг тайлагнах г.м. Зарлагдсан онцгой нөхцөлийн үе шатанд авсан хариу арга хэмжээнээс шалтгаалан үйл ажиллагааны түр зогсолт хийх нь түгээмэл байдаг.

## 2. Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө

### 2.1 Танилцуулга

*ИНД-139.57 - Аэродромын гэрчилгээ*

*ИНД-139.25 – Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ*

ИНД-139-ын дагуу хүсэлт гаргагч нь гэрчилгээ авахаас өмнө холбогдох шаардлагыг хангасан байхыг заасан. Энэ АС-д гэрчилгээ эзэмшигчийн хэрэгжүүлэх арга хэмжээг заасан бөгөөд хүсэлт гаргагчийн талаар огт дурдаагүй, учир нь гэрчилгээ эзэмшигч гэрчилгээг анх авах үед тавигдсантай ижил шаардлагын хэрэгжилтийг үргэлжлүүлэн хангах үүрэгтэй.

Аэродромын гэрчилгээ эзэмшигчийн бүх шаардлага тусгагдсан бөгөөд зөвхөн ИНЕГ-ын Даргын гаргасан тодорхойлолт нь хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ авахад хэрэглэгдэнэ.

### 2.2 Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөнд тавих шаардлага

Хүснэгт 1-д АОНТ-ний үндсэн шаардлагыг үзүүлэв.

#### Хүснэгт 1 - АОНТ-ний шаардлага

<i>Аэродромын гэрчилгээ</i>	<i>Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ</i>
АОНТ шаардсан <i>ИНД-139.57 (a)</i>	Даргын тодорхойлолтоор шаардсан бол АОНТ-тэй байна. <i>ИНД-139.25</i>
Ерөнхий заавар АОНТ-г агуулсан байна. <i>ИНД-139.77(a)(7)</i>	Ерөнхий заавар нь АОНТ-нд хамаарах эрсдэлийг удирдахад шаардлагатай журам болон шаардлагыг агуулсан байна. <i>ИНД-139.417(b)(2)</i>
Стандарт болон В Бүлгийн шаардлагыг байнга мөрдөх. <i>ИНД 101(4)</i>	Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журам, төлөвлөгөө, систем болон хөтөлбөрийг дагаж мөрдөх. <i>ИНД-139.451(2)</i>

### 2.3 Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний агуулга

*ИНД-139.57(b)*

АОНТ-нд байх ёстой олон асуудал байдаг. Тэдгээрт дараах зүйл орно:

#### 2.3.1 Онцгой нөхцөлийн төрөл

*ИНД-139.57(b)(1)*

АОНТ нь аэродром болон түүний орчимд онцгой нөхцөл үүссэн үед хариу арга хэмжээ авах үүрэгтэй байгууллагын хоорондын үялдаа холбоо, зохион байгуулалтыг хангах үүрэгтэй.

Тухайн төлөвлөгөөний бүтэц, зохион байгуулалтаас хамааран онцгой нөхцөлийг ерөнхийдөө 2 өөр бүлэгт ангилж болно. Агаарын хөлөг оролцсон болон оролцоогүй. Хэрэв хүсвэл, аюулгүйн хамгаалалттай холбоотой онцгой нөхцөлийг дангаар нь бүлэглэж болно.

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь мөн ажлын бус цагт онцгой нөхцөлийн хариу арга хэмжээг авна. Ялангуяа ажлын бус цагийн АОНТ-д хамгийн түрүүнд ажиллах шаардлагатай хүмүүс жнь: нислэгийн хөдөлгөөний удирдлагын, эсхүл аврах гал унтраах үйлчилгээний.

Энэхүү ажлын хүрээнд терминалын байгууламж дээр онцгой байдлын албадтай хэрхэн холбоо барих болон аэродромын нэр, байршил, өөр ямар мэдээллийг өгөх талаар заасан тэмдэг байрлуулсан байна.

Энэ АС-ын Хавсралт А-д анхаарч үзэх ёстой онцгой нөхцөлийн төрлийг үзүүлсэн болно.

### **2.3.2 Онцгой нөхцөлийн үед шуурхай хариу арга хэмжээ авах журам**

*ИНД-139.157 (b)(2)*

Онцгой нөхцөлийн төрлүүд нь хариу арга хэмжээ авах албадтай холбоо барих журам болон тэдгээрт хэрэгцээт түгшүүрийн дохио өгөх ажиллагааг нарийвчлан багтаасан байна. Үүнд түгшүүр өгөх системийн бүдүүвч болон хариу үйлдлийн түвшинг оруулна.

Энэ АС-ын Хавсралт В-д холбооны систем болон АОНТ-г хариуцсан ажилтныг томилно. Ингэснээр хариуцах эзэнтэй болгохоос гадна журам нь сайжрагдаж байх нөхцөл бүрдэнэ.

АОНТ-ний төлөвлөлт нь маш чухал юм. АОНТ-г үр дүнтэй, ашигтай, ойлгомжтойгоор төлөвлөх нь маш чухал.

Хэрэв аэродромын ойртолтын болон хөөрөлтийн бүс нь их хэмжээний усан дээр, эсхүл аэродром томоохон хэмжээний ус, нуур, цөөрмийн орчимд байрладаг бол тусгайлсан үйл ажиллагаа, мэргэжлийн байгууллагатай байхыг АОНТ-нд заасан байна. Эдгээрт эргийн хамгаалалтын алба, шумбагчид, завьчид тухайн орон нутгийн мэргэжлийн албатай хамтарч ажиллаж болох боломжийг мөн заасан байна. Дээрх авран хамгаалах мэргэжлийн байгууллага нь онцгой нөхцөлийн ердийн сорил, дадлагад хамрагдсан байна.

### **2.3.3 Төлөвлөгөөг хэрэгжүүлэх аргачлал**

*ИНД-139.57(b)(3)*

Аэродромын онцгой нөхцөлийн төрөл, авах арга хэмжээ, хамрагдах ажилтны хувьд хоорондоо харилцан адилгүй. АОНТ-нд түүнд хамрагдах ажилтан нэг бүрийн оролцоо, авах арга хэмжээг тодорхой заасан байх нь чухал. Түүнчлэн онцгой нөхцөлийн үед оролцогч байгууллага бүрийн авах арга хэмжээ болон ОН дуусах үеийн үйл ажиллагааг багтаасан байвал зохино.

### **2.3.4 Байгууллагын үүрэг хариуцлага болон хийх ажил**

*ИНД-139.57(b)(4)*

АОНТ-д оролцогч байгууллага нь үүссэн онцгой нөхцөлийг хяналтандаа авах арга хэмжээ, үйл ажиллагааны журамтай байна. онцгой нөхцөлийн хариу арга хэмжээг бодитой хангах үүднээс оролцогч байгууллагын үүрэг маш нарийн заагдсан байна. Тухайн аэродромд хамаатай дараах нэгжийг багтаасан үндсэн байгууллагууд:

**Аэродром дээр** - Нислэгийн хөдөлгөөний удирдлагын нэгж, аврах болон гал унтраах үйлчилгээ, аэродромын захиргаа, эмнэлгийн үйлчилгээ, аэродромын түрээслэгч, агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ, хилийн хяналтын алба, нисэх буудлын цагдаа

**Аэродромын гадна** - Галын алба, цагдаа, түргэн тусламжийн үйлчилгээ, эмнэлэг, цэргийн алба, иргэний хамгаалалт, орон нутгийн захиргаа, эрэн хайх болон авран туслах төв орно.

Онцгой нөхцөлийн хариу авах арга хэмжээний журам, төлөвлөгөөнд хүний хүчин зүйлийн үндсэн нөхцөлийг тооцсон байна. Үүнд ажилтан нь онцгой нөхцөлийн үед өөрсдийн үүрэг,



бусад хүмүүс, машин тоног төхөөрөмж, мэдээллийн сурвалж, хүрээлэн буй орчинтой хэрхэн зохицох болон хүний хийх боломжгүй зүйлсийг тодорхойлох зэргийг багтаасан байвал зохино.

ICAO Doc 9683 Хүний хүчин зүйлийн талаарх сургалтын заавар нь иргэний нисэхтэй холбоотой хүний хүчин зүйлийн талаарх баримт бичиг. Хүний хүчин зүйлийн жишээ:

- Үйл ажиллагаа эрхлэгчид болон байгууллагад зориулсан хяналтын хуудсыг боловсруулах. Энэ нь хувь хүнийг тодорхой зам, төлөв рүү хөтөлнө.
- Онцгой нөхцөлийн удирдлагын төв (ОНУТ)-ийг ойлгомжтой хаягжуулах болон тэмдэгжүүлэх, эсхүл эргэлзээ төрүүлэхүйц зүйлсийг багасгах үүднээс тоног төхөөрөмжийг удирдах, хянах. Энэ нь бодох үйл ажиллагаа болон буруу шийдвэр гаргах боломжийг багасгадаг.
- АОНТ-г хариуцах ажилтныг томилох. Энэ нь АОНТ-г эзэнтэй болгохоос гадна байнга шинэчлэгдэж байх боломжийг бий болгодог.
- АОНТ-ний бүрдэл, загвар нь маш чухал. Энэ нь АОНТ-г үр дүнтэй, бүтээмжтэй болон ойлгомжтойгоор боловсруулахад чухал үүрэгтэй болно.

Хэрэв аэродромын ойртолтын болон хөөрөлтийн бүс нь их хэмжээний усан дээр, эсхүл аэродром нь томоохон хэмжээний ус, нүүр, цөөрмийн орчимд байрладаг бол тусгайлсан үйл ажиллагаа, мэргэжлийн байгууллагатай байхыг АОНТ-нд заасан байна. Үүнд эргийн хамгаалалтын алба, шумбагчид, завьчид тухайн орон нутгийн мэргэжлийн албатай хамтарч ажиллаж болох боломжийг мөн заасан байна. Эдгээр авран туслах үйлчилгээний мэргэжлийн байгууллага нь онцгой нөхцөлийн ердийн сорил, дадлагад хамрагдсан байна.

### **2.3.5 Онцгой нөхцөлийн удирдлагын төв болон удирдлагын цэгийн үүрэг**

*ИНД-139.57(b)(5)*

Олон улсын нисэх буудал нь онцгой нөхцөлийн үед ашиглах зорилгоор байнгын ОНУТ болон удирдлагын цэгтэй байна. Онцгой нөхцөлийн удирдлагын төв нь аэродромын барилга байгууламжийн нэг хэсэг байх бөгөөд онцгой нөхцөлийг ерөнхийд нь удирдах, зохион байгуулах болон онцгой нөхцөлийн үед авах арга хэмжээний чиглэлийг гаргах үүрэг бүхий ажилтантай байна. Удирдлагын төв нь ОН үүссэн байрлал руу түргэн хугацаанд нүүх, шилжих боломжтой байх, шаардлагатай бол тухайн орчмын байгууллага үүссэн онцгой нөхцөлийн хариу арга хэмжээг зохицуулах үүрэгтэй. ОН-ийн удирдлагын төв болон удирдлагын цэгийн үйл ажиллагааг хянах, удирдах ажилтныг томилсон байна.

Энэ АС-ын Хавсралт В онцгой нөхцөлийн удирдлагын төв болон удирдлагын цэгийн үүрэг, шаардлагыг хэрэгжүүлэх зааврыг агуулсан.

### **2.3.6 Эмнэлгийн болон бусад боломжит төхөөрөмж, техникийн байршил болон тодорхойлолт**

*ИНД-139.57(b)(6)*

АОНТ нь дараах зүйлсийг багтаасан байна:

- Аэродромын онцгой нөхцөлийн боломжит төхөөрөмж, тэдгээрийн байрлал, төрөл
- Эмнэлгийн хангалт болон олон улсын нисэх буудлын зөөврийн төхөөрөмж
- Хөдлөх чадвараа алдсан болон осолд орсон агаарын хөлгийг зөөх, шилжүүлэхэд шаардлагатай төхөөрөмж

Эмнэлгийн төхөөрөмжийг энэ АС-ын Хавсралт С-д заасан.

### **2.3.7 Онцгой нөхцөлд оролцогч байгууллагуудын холбоо барих мэдээлэл**

*ИНД-139.57(b)(7)*

Онцгой нөхцөлийн үед оролцох байгууллагын холбоо барих мэдээлэл нь АОНТ-нд мэдээлэгдсэн байх бөгөөд тогтмол шинэчлэгдэж байх ёстой.

### **2.3.8 Аэродром болон түүний орчмын торлосон зураг**

*ИНД-139.57(b)(8)*

Аэродромын торлосон зураг болон аэродромын хүрээлэн буй орчны торлосон зураг нь арга хэмжээ шаардлагатай байгууллагад зөрчил гарсан газрын байршлыг заахад тусалдаг. Эдгээр торлосон зураг нь шаардлага хангахуйц масштабтай байх ба нарийвчлал нь үншихад хялбар, тодорхойгүй байдал үүсгэхээргүй байна. Эдгээр нь онцгой нөхцөлийн үед шаардлагатай байгууллагыг онцгой нөхцөлийн бодит байрлал руу чиглүүлэхэд тусална. Торлосон зургийн тайлбар нь хүн бүрд эргэлзээ үүсэхээс сэргийлсэн байна.

### **2.3.9 Онцгой нөхцөлийн төлөвлөгөөг сайжруулах журам**

*ИНД-139.57(b)(9)*

АОНТ нь үр дүнтэй бөгөөд зайлшгүй орох ёстой заалтыг энэ журамд багтаасан гэдгийг баталгаажуулсан байна.

АОНТ-өөр гүйцэтгэх үүрэг, хариуцлагаа томилогдсон ажилтан гүйцэтгэх үүрэгтэй гэдэгээ мэддэг байх ба зохих ёсоор сургалтанд хамрагдсан, төлөвлөгөөний сорилт хийгдсэн, онцгой нөхцөлийн дадлага болон бодитоор үүссэн нөхцөлийн дараа хянагдсан, илэрсэн үл тохирлыг залруулсан байх ёстой. Мөн АОНТ-нд хамааралтай бүх байгууллага, хувь хүмүүсийн зохицуулалтыг хийсэн байна. Хэсэг 3-т эдгээр шаардлагыг дэлгэрэнгүй заасан.

Энэ АС-ын Хавсралт D-д АОНТ-г шалгах загварчилсан дасгалын зааварчилгаа өгөгдсөн.

## **2.4 Аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлага**

*ИНД-139.57(c)*

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч АОНТ-г боловсруулахдаа холбогдох бүх байгууллага, хувь хүмүүсийн оролцоог тусгасан байна. АОНТ-нд үүрэг хариуцлага хүлээсэн бүх хууль сахиулах байгууллага, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэгч, аврах болон гал унтраах байгууллага, эмнэлгийн ажилтан болон байгууллага, аэродромын үндсэн түрээслэгч болон бусад бүх хүмүүс оролцсон байна.

Байгууллага болон үйлчилгээ үзүүлэгчийн хоорондын хамтын ажиллагаа нь чухал байдаг. Хэрэв ОНУТ ажилласан бол заагдсан байгууллага бүрийн холбооны төхөөрөмжийн тоноглолт болон шийдвэр гаргалтыг баталгаажуулна.

ИНД-139-ийн дагуу АОНТ-г боловсруулах, ашиглах нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг бол зохион байгуулалттай арга хэмжээ авах бодит үйл ажиллагаа болон туслах арга хэмжээг онцгой нөхцөлийн хороо гаргах нь шилдэг арга байдаг. Аэродромын онцгой нөхцөлийг төлөвлөх хороо нь орон нутгийн байгууллага, эсхүл онцгой байдлын албадаас байгуулсан онцгой нөхцөлийн томоохон нэгдлийн нэг хэсэг байх боломжтой. Аэродромын онцгой нөхцөлийг төлөвлөх хороо нь нисэх буудалд, аэродром дотор болон гадна, эсхүл түүний орчимд

үүссэн онцгой нөхцөлийн хариу арга хэмжээ, сэргээх ажиллагаа болон шаардлагатай хугацаанд, зохион байгуулалттай боловсруулсан төлөвлөгөөг бий болгох үүрэг хүлээсэн байна.

Аэродромын онцгой нөхцөлийг төлөвлөх хороо нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид нэмэлтээр цагдаа, гал унтраах болон түргэн тусламжийн үйлчилгээ, эрэн хайх гал унтраах үйлчилгээ, агаарын тээвэрлэгч, эсхүл агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэгч болон онцгой нөхцөлийн талаар мэдлэгтэй, эсхүл туслалцаа үзүүлэх боломжтой бусад байгууллагаас ихэвчлэн бүрдэнэ. Жнь: орон нутгийн онцгой нөхцөлийг зохицуулах төв, эрүүл мэндийн байгууллага, хүмүүнлэгийн тусламжийн байгууллага орно.

### 3. АОНТ-ний ашиглалт

*ИНД-139.109*

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч үр дүнтэй үйл ажиллагаа бүхий АОНТ-тэй байна. АОНТ нь дараах шаардлагыг зайлшгүй агуулсан байна:

- (a) Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч АОНТ-нд тусгасан үүрэг хариуцлагыг хүлээсэн ажилтан өөрийн томилогдсон ажил үүргийн талаар мэддэг, шаардлагатай сургалтанд хамрагдсан байх.
- (b) АОНТ-г шалгах ажиллагааг дараах 2 аргаар хийнэ:
  - (i) Аэродромын онцгой нөхцөлийн бүрэн хэмжээний дасгал сургуулилтыг хамгийн багадаа 2 жилд нэг удаа хийх, бүрэн хэмжээний сургуулилтын үед илэрсэн үл тохирлыг залруулсныг бататгах зорилгоор тусгай дасгал сургуулилтыг явуулах.
  - (ii) Цуврал шалгалтын үе шат нь 3 жил тутамд хийгдэх, АОНТ-г мөрдөж эхэлснээс хойш 3 жилээс хэтрэхгүй хугацаанд бүрэн хэмжээний дасгал сургуулилтыг хийх.
- (c) Онцгой нөхцөлийн бодит тохиолдол болон сургуулилтын дараа дүгнэлт хийх, илэрсэн үл тохирлыг засах.
- (d) Хууль сахиулах байгууллага, аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэгч, аврах болон гал унтраах байгууллага, эмнэлгийн ажилтан болон эмнэлгийн байгууллага, аэродромын үндсэн түрээслэгч АОНТ-нд үүрэг хүлээж байгаа бүх байгууллага, хүмүүстэй хамтран зохицуулалт хийсэн байна.

Энэ АС-ын Хавсралт D-д онцгой нөхцөлийн үед хийх загварчилсан дасгалын зааварчилгаа өгөгдсөн болно.

### 4. АОНТ-ний удирдлага

#### 4.1 Баримт бичгийн бүтэц

АОНТ нь тухайн орон нутгийн шаардлагад нийцсэн, аэродромын үйл ажиллагааны төрлөөс хамаарсан бүтэцтэй байна. Учир нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн олон төрлийн ажлын хүрээнээс шалтгаалж АОНТ-ний шинж байдлыг харуулсан тодорхой стандарт байдаггүй. Гэсэн хэдий ч АОНТ нь аэродромын үйл ажиллагааны төрлөөс хамаарсан түвшинд ИНД-139-ийн шаардлагыг хангасан байна.

АОНТ нь ерөнхийдөө хэсэг болон дэд хэсэгт хуваагддаг, үндсэн хоёр хэлбэрийн нэгийг нь дагадаг:

- (a) Онцгой нөхцөлийн үед тодорхой үүрэг, хариуцлага бүхий байгууллага бүр нь бүрэн хэмжээний төлөвлөгөө бүхий өөрийн хэсэгт онцгой нөхцөлийн төрөл бүрд авах арга хэмжээг багтаасан дэд хэсгийн хамт орсон байх:
- (b) Бүрэн хэмжээний төлөвлөгөө нь онцгой нөхцөлийн төрөл бүрд шаардлагатай арга хэмжээг үзүүлсэн хэсэгт, энэхүү төлөвлөгөөний дагуу байгууллага бүрийн авах арга хэмжээ нь дэд хэсэгт орсон байхаар боловсруулагдана.

#### **4.2 АОНТ-ний баримт бичгийн зохицуулалт**

АОНТ-ний зохицуулалт болон хуваарилалттай холбоотой нилээд хэмжээний асуудал үүсдэг.

АОНТ-ний хамгийн түгээмэл асуудал нь нилээд хэмжээний боловсруулагдах хуудас болон тогтмол шинэчлэгдэж байх шаардлага юм. Баримт бичиг нь өөрөө зардал болохоос гадна удирдлагын үйл ажиллагаа болон АОНТ-ний шинэчлэлт, өөрчлөлттийн зардал нь дарамт болдог талтай.

Энэ асуудлыг шийдвэрлэх нэг арга нь АОНТ-ний цувралын тоог багасгах болно. Байгууллага АОНТ-ээс зөвхөн өөрсдийн холбогдох хэсгийг ихэвчлэн шаарддаг. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд зарим нисэх буудал тухайн байгууллагад хамааралтай асуудлыг хэсэгчилж болон тохируулж гаргасан АОНТ-ний багцыг тарааж эхэлсэн. Энэ нь нисэх буудлын операторын холбогдох байгууллагад тараах ёстой хуудсын хэмжээг багасгасан болно.

Мөн энэ асуудлыг шийдэх нэг арга зам бол цахим АОНТ хийх юм. Ялангуяа хатуу дискэнд хуулбарлах, цахим шуудангаар болон аэродромын үйл ажиллагаа хамгаалалттай цахим хуудсаар тарааж болно. Оролцогч байгууллага нь өөрсдийн холбогдох хэсгийг хэвлэн авч аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн олгосон АОНТ-ний хавтаст түүвэрлэн оруулна. Мөн өөр нэгэн шаардлагатай ажил нь энэхүү журмыг тогтмол шинэчлэх асуудал байдаг. Холбоо барих утасны дугаар, холбогдох хүүмүүсийн хаяг, байгууллагын бүтэц дэх албан тушаал болон бүх зүйлс нь хуваарийн дагуу солигдож байна. Холбоо барих хаягийг хамгийн багадаа жилд 1 удаа хянаж, баталгаажсан эсэхийг тогтоосон байна.

#### **4.3 Төлөвлөгөөг хянах**

АОНТ-ний хамгийн чухал хэсэг нь онцгой нөхцөлд авах арга хэмжээг хянах юм. АОНТ-ний хяналт нь дараах тохиолдолд хийгдэнэ:

- Хуваарьт төлөвлөгдсөн үйл ажиллагаа:
- Онцгой нөхцөлийн сургуулилт:
- Бодит онцгой нөхцөлийн дараах тайлан:
- Бусад газраас авсан судалгаа.

АОНТ-ний үр дүнг нэмэгдүүлэх үүднээс аливаа өөрчлөлт хийгдэж байх ёстой.

#### **4.4 Баримт бичгийн хяналт**

АОНТ нь дараах зүйлсийг баталгаажуулах үүднээс хянагдаж байна:

- Журманд заагдсаны дагуу үүрэг хариуцлага хүлээх бүх байгууллага болон хүмүүст АОНТ-ний холбогдох сүүлчийн хувилбар хэсэг нь байх ёстой.

- Бүх хуучин хэсгийг нэн даруй хасах ёстой.
- АОНТ-ний сүүлчийн хувилбар нь өмнөх хүчингүй болсон хувилбарын хэрэглээг байхгүй болгож байгаа эсэх нь тодорхойлогдсон байна.

## Хавсралт А – Аэродромын онцгой нөхцөлийн төрөл

### А.1 Танилцуулга

AIP-д оруулахад анхаарах ёстой онцгой нөхцөлийн жагсаалтыг дор харуулав. Тодорхой болгох зорилгоор гурван ангилалд хуваасан: агаарын хөлгийн онцгүй нөхцөл, аюулгүйн хамгаалалтын болон бусад онцгой нөхцөл.

### А.2 Агаарын хөлгийн онцгой нөхцөл

Аэродромын онцгой нөхцөлийн үеийн нисгэгчид зориулсан мэдээллийг AIP Mongolia, ENR1.15-д нарийвчлан тусгасан байх ба дараах онцгой нөхцөлийн үе шатууд болон тэдгээрийг НХУ-ын нэгжид хэрхэн идэвхижүүлэх талаар тусгасан болно.

#### А.2.1 Дотоодын бэлэн байдал

Аюулгүйн буулт үйлдэхэд огт саадгүй боловч өөр ямар нэгэн асуудал үүссэн гэж сэжиглэгдсэн, эсхүл тогтоогдсон агаарын хөлөг аэродром руу ойртолт үйлдэж байгаа бол дотоодын бэлэн байдлын үе шатыг зарладаг. ДОТООДЫН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕ ШАТ-ыг зарлах үед аэродромын онцгой байдлын албадыг бэлэн байдалд шилжүүлэх бөгөөд аэродромын бус албад нь мэдээлэл авсан ч өөрсдийн байрладаг цэг дээр бэлэн байх үе шатанд шилжинэ.

Мөн бэлэн байдлын бусад үйл ажиллагаа хангагдсан эсэхийг баталгаажуулна.

#### А.2.2 Онцгой нөхцөлийн бүрэн хэмжээний бэлэн байдал

Ослын аюул бүхий асуудал үүссэн гэж сэжиглэгдсэн, эсхүл тогтоогдсон агаарын хөлөг аэродром руу ойртолт үйлдэж байгаа үед онцгой нөхцөлийн бүрэн хэмжээний бэлэн байдлын үе шатыг зарлана. БҮРЭН ХЭМЖЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕ ШАТ-ыг зарлах үед түргэн тусламж болон эмнэлгийн үйлчилгээ, цагдаа, галын алба г.м аэродромын болон орчмын онцгой байдлын бүх албад, тоног төхөөрөмж аэродромын уулзах бүс буюу цаашид зөрчлийн үед цугларах, эсхүл бөөгнөрөх бүс болох боломжтой цэгт бэлэн байдалд байна. Энэ үед мөн гэмтэж бэртсэн хүмүүсийг хүлээн авахад эмнэлгийг бэлэн байлгах, онцгой нөхцөлийн тээврийн хэрэгслийг саадгүй явуулах үүднээс замын хөдөлгөөний хяналтын албыг бэлэн байлгах түгшүүрийг өгдөг болно.

Мөн бэлэн байдлын бусад үйл ажиллагаа хангагдсан эсэхийг баталгаажуулна.

#### А.2.3 Агаарын хөлгийн осол

Аэродром дотор болон түүний орчимд агаарын хөлгийн осол, эсхүл сүйрэл гарсан үед ослын үе шатыг зарлана. АГААРЫН ХӨЛГИЙН ОСЛЫН ҮЕ ШАТ, ЭСХҮЛ СҮЙРЭЛ аль ч байрлалд гарч болно. Ослын байрлалаас хамаараад аэродромын байгууллагын авах бодит арга хэмжээ нь өөр өөр байна.

Энэ үеийг АОНТ-ний төлөвлөлтөнд ICAO-аас 2 ерөнхий байршлыг сонгож тооцохоор заасан байдаг. Энэ нь нисэх буудлын дотор болон гадна гэсэн нөхцөлтэй. Нисэх буудлын гадна гэдэг нь аэродромыг хүрээлэн буй газарзүйн нөхцөлөөс хамаарах бөгөөд үүнийг нисэх буудлын гадна хуурай болон усан дээр гарсан осол гэж хуваагдана.

Аэродром орчмын газарзүйн байршлаас хамаарч ослын үе шатны тогтоосон төрөл, мөн ослын үед авах арга хэмжээг АОНТ-нд заасан байх нь чухал юм. Жнь: зарим аэродром нь аэродромын дотор гэдгийг түүнийг хүрээлэн буй периметрийн хашаагаар тооцдог. Зарим нь ХБЗ-ны

төгсгөлийн цэгээс 2 тийш /гадна/ 300м-ийн өргөнтэй нийт 1000м хэсэгт буюу ойртолтын болон хөөрөлтийн бүсийг оролцуулж тооцдог.

Нисэх буудлын гадна гэдэг тодорхойлолт нь өөр өөр байх боломжтой. ICAO-гийн шаардлагаар АОНТ-ний хүрээнд нисэх буудлын орчим, эргэн тойронд 8 км радиус бүхий талбайг тооцсон байна гэж заадаг. 8 км-ийн энэхүү бүсэд онцгой нөхцөлийн хариу арга хэмжээг бүхэлд нь авах талаар зөвхөн АОНТ-нд заах нь боломжгүй байх магадлалтай. Хэрэв энэ бүс нь хотын төвийн барилгажсан бүс бол иргэний хамгаалалт, цагдаа, гал унтраах албад илүү оролцоотой байна.

Энэ зохицуулалт нь алслагдсан бүсэд мөн адил хамаарна. Хэдийгээр ICAO шаардаагүй боловч энэ нь АОНТ-ний нэг бүрдэл хэсэг болсоор байна. Ослын газар дээр ажиллах байгууллага хоорондын зохицуулалтыг хийхэд мөн аэродромын нөөцийг тухайн зөрчилд хамруулах, эс хамруулах талаар АОНТ нь үндсэн баримт бичиг болж чаддаггүй тул аэродром дээр байгууллагын оролцоо, идэвхижүүлэлтийг шаардсан АОНТ-ний заалт байх ёстой. Аэродромоос алслагдсан зайд үүссэн агаарын хөлгийн ослын үед авах арга хэмжээний хүрээ багасах магадлалтай бөгөөд үүнийг тусдаа ослын үе шат болгон авч үзэх шаардлагатай.

Агаарын хөлгийн ослын үед анхаарах өөр нэг асуудал нь цэргийн агаарын хөлөгтэй хамтран тусгай ажиллагаа боловсруулах юм. Онцгой байдлын ерөнхий газар нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид ослын тохиолдолд авах арга хэмжээ, үйл ажиллагааг төлөвлөхөд туслах зорилготой.

### **А.3 Анхаарах асуудал**

Төлөвлөлтийн арга хэмжээнээс хамаарч шаардагдах зүйлс:

- Агаарын хөлөг хөөрөх болон буух шаардлагатай байсан аэродром дээр цугларсан уулзагсад болон гашуудагсад, ялангуяа, тэдгээрийн хамаатан садан болон хэвлэл мэдээллийн хүмүүс. Түүнлэн терминалын зохион байгуулалтын ажилд анхаарах ёстой.
- Ослын нөхцөл нь тодорхойгүй байх хугацаанд анхаарал тавих үүднээс хамаатан садан болон бусад хүмүүст зориулсан тусгайлсан бүс гаргах.
- Нислэгийн мэдээллийн дэлгэцээр тухайн нислэгтэй холбоотой мэдээллийг харуулж байх.
- Хэвлэл мэдээллийн зохицуулалт болох хяналт.
- Гаднаас ирэх асуулт, хүсэлттэй холбоотойгоор холбооны сүлжээнд хэт ачаалал үүсэх.
- Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид холбоо болон логистикийн туслалцаа үзүүлэх.
- Осолд нэрвэгдсэн агаарын хөлгийн багийг зорчигчоос тусгаарласан зорчигчид болон агаарын хөлгийн багийг байрлуулах газраар хангах.
- Аэродромыг хаах болон хязгаарлалт хийх NOTAM мэдээг зарлах, агаарын тээвэрлэгчдийн холбоо болон ИНЕГ-аас агаарын зайд хязгаарлалт хийх.
- Агаарын хөлгийн бүрэлдэхүүн, зорчигчдыг осол болсон газраас өөр газарт буюу ослын талбар үл харагдах байрлалд нүүлгэх, бүх хүмүүсийг бүртгэж, тоолсон эсэхийг бататгах.
- Осолд нэрвэгдэгсдийг тусгаарласан байранд байлгах буюу шаардлагатай хэрэгсэл, утсан холбоо, интернетийн холболт г.м зүйлээр хангах.

- Эмнэлгийн байгууламжид орох түргэн тусламж, эмнэлэг болон тээвэрлэх хэрэгсэл болох автобус, нисдэг тэргийг бэлтгэх.

### **А.3.1 Газар дээрх зөрчил**

Энэ онцгой нөхцөлийн үе шат нь агаарын хөлөгтэй холбоотой, агаарын хөлөг газарт байх үед тохиолддог. Дараах нөхцөл байдал энэ тохиолдлын жишээ болох бөгөөд үүнд газарт байсан агаарын хөлөгт ихэвчлэн хэт халсан тоормозны систем, агаарын хөлөг болон тээврийн хэрэгсэл бусад барилга байгууламжтай мөргөлдөх зэргээс шалтгаалан гал гарах орно.

### **А.3.2 Хөдлөх чадвараа алдсан агаарын хөлөг**

Энэ онцгой нөхцөлийн үе шат нь агаарын хөлөгтэй холбоотой, аэродромын хөдөлгөөний бүсэд явж байсан агаарын хөлөг хүчилттай талбайгаас гарах, эсхүл дугуй буудах г.м асуудлаас шалтгаалж хөдлөх чадвараа алдах орно. Энэ үе шат агаарын хөлгийг сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажиллагааг идэвхижүүлнэ. Агаарын хөлгийг сэргээх үе шат нь ослын үед АОНТ-ний сэргээх үе шат автоматаар хэрэгжиж эхэлнэ.

### **А.3.3 Усны орчим дахь аэродром**

Томоохон хэмжээний үс болох далай тэнгис, эсхүл нуурын ойрхон байрласан аэродром нь жнь: нуур, эсхүл далай тэнгисийн усанд осолдох аваар ослын үед аврах болон гал унтраах тусгай арга хэмжээг авах үүрэгтэй. Энэхүү ажиллагаанд усан онгоц, завь, усанд хөвөгч нэмэлт аврах хэрэгслээс гадна биеийн дулаан алдагдахаас сэргийлсэн хөнжил, хөвөгч аврах хантааз хэрэглэгдэнэ.

Нэмэлт мэдээллийг ICAO Doc 9137 - Нисэх буудлын ашиглалтын заавар Хэсэг 7, Нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөлт, Хавсралт 6-д байгаа болно.

## **А.4 Аюулгүйн хамгаалалтын онцгой нөхцөл**

Аюулгүйн хамгаалалтын онцгой нөхцөлийн журам нь Аюулгүйн Хамгаалалтын Үндэсний Хөтөлбөр, Аэродромын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр болон Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөртэй үялдсан байна. Нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын мэдлэг олгох сургалт нь эдгээр аюулгүйн хамгаалалтын онцгой нөхцөлийн үе шаттай үялдсан байна.

### **А.4.1 Хорлон сүйтгэх ажиллагаа**

Энэ онцгой нөхцөлийн үе шат нь агаарын хөлөг, эсхүл агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлөх навигацийн байгууламжийн эсрэг хорлон сүйтгэх ажиллагаа гэж сэжиглэгдсэн, эсхүл тогтоогдсон тохиолдолтой холбоотой. Авах арга хэмжээ:

- Агаарын хөлөг, багийн гишүүн болон зорчигчийн аюулгүй байдлыг баталгаажуулах.
- Хорлон сүйтгэх ажиллагааны цаашдын оролдлого, эсхүл нотолгоо, баримтыг шалгах.
- Хорлон сүйтгэх дараагийн ажиллагаанд тавих анхаарлыг илүү өндөр түвшинд хүргэх.
- Хорлон сүйтгэх ажиллагааны эх үүсвэрийг олоход чиглэсэн нөхцөл байдлын талаарх мөрдлөгийн ажиллагаа



#### **А.4.2 Хууль бус эзэмшилт (барьцаалалт)**

Энэ онцгой нөхцөлийн үе шат нь агаарын хөлгийг булаах, өөрийн болгох үйлдэл, эсхүл хүн болон хүмүүс бусдын эрхшээлд орох, өөрсдийн зорилгыг биелүүлэхэд дэмжлэг болгох үүднээс заналхийлэл үзүүлэх тохиолдлуудтай холбоотой. Үүний эсрэг хариу үйлдлийг тусгай хүчин үзүүлэх, барьцаалах ажиллагаа нь даамжирсан эсэхээс шалтгаалаад аврах ажиллагааг удирдах байгууллага нь өөрчлөгдөнө.

Агаарын тээвэрлэгчийн авах арга хэмжээнд бусад агаарын хөлөг, эд хөрөнгө, эсхүл хүмүүст учирч болох эрсдэлийг бууруулах үүднээс тусгаарлах зогсоолтой байх шаардлага тавигдсан. Энэхүү талбай нь бусад барилга байгууламж, нислэгийн зам, нислэгийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх боломжгүйгээр буюу хамгийн багадаа 100м зайд тусгаарлагдсан байна. Мөн тусгаарлах зогсоолыг үзэгдэх орчин хязгаарлагдсан үед гэрэлтүүлгийн хэрэгслээр тоногдсон байх, эсхүл зөөврийн гэрэлтүүлгийн хэрэгслийг 30 минутын дотор суурилуулсан байна.

#### **А.4.3 Тэсрэх бөмбөгөөр заналхийлэх (агаарын хөлөг)**

Энэ онцгой нөхцөлийн үе шат нь албан болон албан бусаар, эсхүл бичгээр болон амаар агаарын хөлөг, агаарын тээвэрлэгч, эсхүл зорчигчийн эсрэг тэсрэх бөмбөгөөр заналхийлэх тохиолдолтой холбоотой. Энэ онцгой нөхцөлийн үе шатыг эхлүүлэхийн өмнө энэ нь заль мэх эсэх, эсхүл онцгой нөхцөлийн ажиллагааг идэвхижүүлэх шаардлагатай эсэхийг тогтоохын тулд боломжит байг тогтоох заналхийллийн үнэлгээний аргачлалыг ашиглах нь түгээмэл байдаг. Онцгой нөхцөлийг удирдах байгууллагын ажиллагаа, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ, эсхүл агаарын тээвэрлэгч байгууллагын онцгой нөхцөлийг ямар нэгэн шатанд идэвхижүүлэх хүсэлтэд саад болох ёсгүй.

ИНЕГ нь заналхийллийн зохицуулалтын ажиллагаа шаардлагатай болсон нөхцөлд 3 онцгой болон тусгай нөхцөлийг тогтоосон. Эдгээрийг дараах үед хэрэглэнэ:

- (a) Агаарын хөлгийн хаалга хаалттай үед газарт болон агаарт заналхийлсэн;
- (b) Агаарын хөлгийн хаалга нээлттэй үед газарт заналхийлсэн;
- (c) Нисэхийн байгууламжид заналхийлсэн г.м.

Дээрх 3 тусгай нөхцөл бүрд гүйцэтгэх үүрэг, хариуцлагын өөрчлөлт нь өөр өөр хандлагатай байдаг. Заналхийллийг хүлээн авах ажиллагаа нь Аюулгүйн Хамгаалалтын Үндэсний Хөтөлбөр болон холбогдох тусгай арга хэмжээний гарын авлага Нисэхийн Аюулгүйн Хамгаалалтын Ноцтой Мэдээлэл-д заагдсан болно.

#### **А.4.4 Эзэнгүй ачаа**

Эзэнгүй ачаанд шошготой болон шошгогүй цүнх, эсхүл бусад зүйлс дараах тохиолдол орно:

- Тухайн бүсэд байрлах зөвшөөрөлгүй байх
- Хүн болон эд хөрөнгөнд эвдрэл, гэмтэл учруулж болох боломжтой гэж тооцогдсон
- Харагдац болон байршил аль аль нь сэжигтэй гэж үзсэн г.м.

Нисэх буудлын дотоодын холбогдох алба нь үзлэгийн арга хэмжээ авагдах үед зохих баталгаажуулалтын арга хэмжээг авна. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээнд ачаа нь эрсдэл мөн эсэхийг тогтоохоор тэсрэх бөмбөг илрүүлэх төхөөрөмж, нохой, цацраг илрүүлэгч зөөврийн хэрэгслийг ашиглана. Энэ онцгой нөхцөлийн үе шат нь ерөнхийдөө ачааны эзэн олдохгүй, эсхүл ачаагаа авахгүй буюу 5-10 минутын турш байсаар байвал аюулгүйн үзлэгийн

дараа онцгой нөхцөл зарлах эсэхийг шийднэ. Хариу арга хэмжээ нь эзэнгүй ачааг аюулгүй гэж тогтоох хүртэл танхимаас зорчигчдыг гаргах явдал юм.

#### **А.4.5 Сэжигтэй зүйл**

Сэжигтэй зүйл гэдэг нь аюулгүйн хамгаалалтын үзлэгийн төхөөрөмжөөр тэсрэх зүйлс байгаа нь илэрсэн ачааны зарим хэсэг, эсхүл ачаа дамжуулах систем дэх баглаа, боодолтой зүйл болон ачааны эзнийг үзлэгт хамруулах боломжгүй, эсхүл тодорхой бус зүйлийг хэлнэ.

Энэ онцгой нөхцөлийн үе шат нь нисэх буудлын аюулгүйн үзлэгийн эцсийн шат хүртэл идэвхитэй байх мөн сэжиг бүхий зүйл нь аюулгүй гэдэг нь батлагдах хүртэл үргэлжилнэ.

Үүнтэй төстэй ажиллагаа нь бас ачаа тээшний терминалын хяналтын дэлгэцийн үзлэгээр ачаа нь сэжигтэй гэж тогтоогдсон мөн ачааг таних холбогдох үйл ажиллагааны явцад мөрдөгдөх боломжтой. Энэ онцгой нөхцөлийн үе шат нь зөвхөн хяналтын дэлгэц бүхий ачаа тээш болон ачаа дамжуулах систем дээр тэсрэх бодис илрүүлэх төхөөрөмж суурилагдсан нисэх буудалд ашиглагдах боломжтой.

#### **А.4.6 Тэсрэх бөмбөгөөр заналхийлэх /барилга байгууламж/**

Энэ онцгой нөхцөлийн үе шат албан болон албан бусаар, эсхүл бичгээр болон амаар барилга байгууламжийн дотор, эсхүл ойр орчимд суурилуулагдаж, доторх хүмүүст аюул тулгарсан, эсхүл бусад хүмүүст шууд биш аюул учруулахаар заналхийлэх агшин юм.

Зарим аэродромын үйл ажиллагаа эрхлэгч агаарын хөлөгт ашиглагддаг заналхийллийг үнэлэх аргачлалыг барилга, байгууламжид заналхийлэл учирсан эсэх нь тодорхой болон тодорхой бус гэдгийг тогтоохын тулд хэрэглэдэг.

Энэ нь хэвийн үйл ажиллагааг алдагдуулах томоохон нөлөөллийг багасгах арга хэмжээг тогтооход туслах боломжтой.

ИНЕГ нь заналхийллийн зохицуулалтын ажиллагаа шаардлагатай болсон нөхцөлд онцгой болон тусгай нөхцөлийг тогтоосон. Эдгээр нь дараах нөхцөлд хэрэглэгдэнэ:

- (a) Агаарын хөлгийн хаалга хаалттай үед газарт болон агаарт заналхийлсэн;
- (b) Агаарын хөлгийн хаалга нээлттэй үед газарт заналхийлсэн;
- (c) Нисэхийн байгууламжид заналхийлсэн г.м.

Дээрх 3 тусгай нөхцөл бүрд гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг өөрчлөлт нь өөр өөр хандлагатай байдаг. Заналхийллийг хүлээн авах ажиллагаа нь Аюулгүйн Хамгаалалтын Үндэсний Хөтөлбөр-д заагдсан болно.

#### **А.4.7 Нийтийг хамарсан үймээн самуун**

Аэродром болон нисэх буудал дээр нийтийг хамарсан үймээн самуун үүссэн үед онцгой нөхцөлийн үе шатыг хэрэглэнэ. Нийтийн үймээн самуун гэдэг нь бүлэг хүмүүсийн нэгдэл аэродромын үйл ажиллагааг зориудаар тасалдуулахаар тухайн талбар дээр цугларах үзэгдэл, эсхүл эд хөрөнгийг сүйтгэх үйл ажиллагааг хэлнэ.

Жишээ нь нисэх буудлын түрээслэгчийн эсрэг довтлох, терминалын барилга руу явсан замыг хаах, эсхүл жагсагчид агаарын хөлгийн хөдөлгөөний бүсэд нэвтэрч нислэгийн үйл ажиллагааг тасалдуулах г.м.

## **А.5 Бусад онцгой нөхцөл**

### **А.5.1 Байгалийн гамшиг**

Аэродром нь өөрийн бүсэд буй аюулыг үнэлэхэд туслах үүднээс өөрийн авран хамгаалах багтай ойр ажиллах шаардлагатай. Үндэсний авран хамгаалах нэгжээр нэрлэгдсэн эдгээр аэродром нь мөн энэ журамд ороогүй бусад эрсдэлийг Иргэний Хамгаалалтын Үндэсний Төлөвлөгөөний шаардлагын дагуу биелүүлэх үүрэгтэй.

Газар хөдлөлт, салхи шуурга, үер, галт уулын дэлбэрэлт байгалийн гамшиг, эсхүл цунами анхааруулга нь онцгой нөхцөлийн иргэний хамгаалалтын асуудалд хамаарах бөгөөд аэродромын тусгай арга хэмжээний журам нь тухайн гамшгийн тохиолдол бүрд, эсхүл хосолсон байдлаар боловсруулагдсан байна.

Газар хөдлөлт, гал түймэр, хүчтэй шуурга нь тохиолдох магадлал өндөр тул эдгээрт илүү анхаарах шаардлагатай. Онцгой нөхцөлийн эдгээр үе шат нь хүний амь нас болон агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлөхөөр бол зарлах ёстой.

Газар хөдлөлтийн нөлөөллөөр аэродромын барилга, шатахууны сав, харааны болон радио навигацийн тоноглол, ХБЗ-үс хүчилтэй талбай нь эвдрэх магадлалтай. Аэродромын эдгээр байгууламж нь онцгой нөхцөлийн үе шат бүрийн дараа тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, эвдрэл гэмтэл, нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх зэргийг шалгах ёстой.

Онцгой нөхцөлийн үе шатыг зөвхөн нисэх буудлын байгууллагуудад анхааруулснаар тухайн ажилтан, агаарын хөлөг болон зорчигчийн аюулгүй байдалд аюулгүй учруулахгүйн тулд байгууламж болон үйлчилгээний зохих үнэлгээг хийнэ.

Шуурга нь хүчтэй салхи болон бороог үүсгэснээр гадаа талбай дээрх ажилтан болон зорчигчийн аюулгүй байдал мөн газар дээрх агаарын хөлөг болон бусад төхөөрөмжид аюул учруулж болзошгүй юм. Энэ тохиолдолд ерөнхийдөө эрсдэлийн хэмжээг бууруулах талаар арга хэмжээ авахыг зөвлөдөг. Үүнтэй холбоотой онцгой нөхцөлийн үе шатыг заагдсан хэмжээнээс илүү гарсан, аюулгүй ажиллагааны нөхцөл алдагдсан үед зарлана. Хүн бэртээгүй, эд хөрөнгөд томоохон эвдрэл тохиолдоогүй бол зөвхөн нисэх буудлын албадад энэ үе шатыг мэдээлнэ.

### **А.5.2 Объектийн, эсхүл газар дээрх гал**

Энэ онцгой нөхцөлийн үе шатыг агаарын хөлгөөс бусад аэродромын байгууламжид гал гарсан үед зарлана.

### **А.5.3 Аюултай бодис**

Энэ онцгой нөхцөлийн үе шатыг аэродром дээр аюултай бодис асгарах үед зарлана. Аюултай бараа агуулсан хайрцаг нь талст хэлбэр бүхий аюултай бараа гэсэн шошготой байна. Аюултай бодисын олон тохиолдол нь ажилтанд тусгай анхааруулга өгч байхыг шаарддаг.

Түлш асгарах тохиолдол нь их байдаг бөгөөд энэхүү асуудал нь АОНТ-нд байгаа эсэхэд анхаарал хандуулах ёстой. Түлшний асгаралтыг “Аэродромын осол”-ын ерөнхий үе шатанд шийдвэрлэх боломжтой бөгөөд хэрэв асгарсан хэмжээ нь зөвшөөрвөл хариу арга хэмжээ авах түвшинг нэмэгдүүлэх болно.

#### **А.5.4 Эмнэлгийн онцгой нөхцөл**

Эмнэлгийн яаралтай тохиолдол ихэвчлэн нисэх буудал дээр гардаг. Ихэнхдээ хүмүүст зүрхний шигдээс, зогисох, унах, амьсгалын хүндрэл, нислэгийн үед дотор муухайрах г.м хүндрэл тохиолддог.

Эдгээрт нисэх буудлын ажилтнууд шаардлагатай тохиолдолд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын түргэн тусламжийн эмч, эмч нарыг ирэх хүртэл хариу өгдөг.

АОНТ нь энэ тохиолдолд ихэнхдээ идэвхиждэггүй. Гэсэн ч эмнэлгийн онцгой нөхцөлийн үе шатанд шаардлагатай арга хэмжээг авсан байх ёстой бөгөөд нилээд хүн гэмтэж бэртсэн тохиолдолд нисэх буудлын ажилтан арга хэмжээ авах боломжгүй юм.

Агаарын хөлгийн хүчтэй сэгсрэлтээс болж зорчигчид гэмтэх, бие муудах эрүүл мэндийн асуудал ихээр үүснэ.

Эмнэлгийн онцгой нөхцөлд зорчигчдод хордлого өвчний шинж тэмдэг илэрсэн үед онцгой анхаарал халамж шаардлагатай байдаг. Халуурах /38° -аас дээш хэм хүртэл/, ойрхон бөөлжих, суулгах, эсхүл биеийн арьсан дээр тууралт гарах нь өвчний шинж тэмдэгт орно.

Эдгээр зорчигчдод хөл хорио тогтоох онцгой арга хэмжээ авах шаардлагатай болдог.

Хөл хорио тогтоох нь бие тавгүйрхсэн зорчигчийн өвчний шалтгааныг тогтоотол үргэлжлэх магадлалтай бөгөөд олон зорчигчийг хамарсан хоолны хордлого байх эсэхийг мөн нягтална.

#### **А.5.5 Нисэх буудалд гарсан зөрчил**

Энэ онцгой нөхцөлийн үе шатанд нисэх буудлын гаднах байгууллагаас тусламж авах онцын шаардлагагүй тохиолдолд хамаарна.

Нисэх буудлын харъяа албадад мэдээлэх боломжтой бөгөөд шаардлагатай авах арга хэмжээг авах боломжтой тээврийн хэрэгслийн осол, түлш асгарах, зарим бага зэргийн эмнэлгийн онцгой нөхцөл нь үүнд хамаарна.

### **А.6 Дэмжих төлөвлөгөө**

#### **А.6.1 Терминалын нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө**

Терминалын нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь тусгайлан зарлагдсан онцгой нөхцөлийн дагуу хэрэгждэг. Жишээ нь аюулгүйн хамгаалалтын зөрчил, барилга байгууламжийн гал, аюултай бодис асгарах г.м. Терминалын нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө нь АОНТ-ний нэг хэсэг байх боломжтой, эсхүл АОНТ-нд заасан тусдаа баримт бичиг байж болно.

#### **А.6.2 Тусламж үзүүлэх төлөвлөгөө**

Онцгой нөхцөлийн хариу арга хэмжээ, эсхүл сэргээн засах үе шатанд тусламж үзүүлэх, олон нийттэй харьцах зохих байгууллагын туслалцааг авах шаардлага үүсдэг.

Эдгээр нь дараах тохиолдолд хэрэглэгдэнэ:

Угтан авагчид болон үдэгчидтэй харилцах.

Яаралтай тусламж шаардлагагүй амьд үлдэгсдийг анхаарах.

Ажилтанд шаардлагатай тусламж үзүүлэх, ослын дараах мэдээллийг илтгэх

Ослын талбар руу эргэж нэвтрэхийг хүссэн амьд үлдэгсэд болон хамаатан садантай харилцах.

Аэродромын онцгой нөхцөлийг Төлөвлөх хороо АОНТ-ний арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх олон нийтийн тусламж үзүүлэх журмыг боловсруулах асуудлыг анхаарах шаардлагатай. Нийтийн тусламж үзүүлэх журам нь АОНТ-ний нэг хэсэг байж болох, эсхүл АОНТ-нд заасан тусдаа баримт бичиг байж болно.

Ихэнх агаарын тээвэрлэгчийг нийтийн тусламж үзүүлэх журамтай байхаар заасан бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй тусгайлан сургасан ажилтантай байх шаардлагатай. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон агаарын тээвэрлэгч нь бие биенийхээ нийтийн туслалцаа үзүүлэх журмын талаар бүрэн мэдлэгтэй байна.

Хохирогсдод тусламж үзүүлэх, Аврах анги, Улаан загалмайн нийгэмлэг нь нийтийн туслалцаа үзүүлэхэд сургалтанд хамрагдсан ажилтантай байдаг.

*Угтан авагч болон үдэгчид халамж үзүүлэх*

Онцгой нөхцөлийн хариу арга хэмжээний үе шатанд осолд нэрвэгдсэн зорчигчдын талаарх мэдээллийг олох ажилд /таних, тогтоох болон нийлүүлэх ажиллагаанд/ цагдаагийн газарт туслах, угтагч болон үдэгчид анхаарал халамж үзүүлэх ажилд нэмэлт хүч шаардлагатай болдог.

Хүчтэй лидерийг татан оролцуулах болон англи, Монгол хэл мэддэггүй зорчигч олон байгааг тооцон орчуулагч нарыг оролцуулах асуудлыг анхаарах ёстой.

Нэмэлт мэдээлэл энэ АС-ын Хавсралт Е-д орсон болно.

*Амьд үлдэгсдийг халамжлах*

Яаралтай тусламж авах шаардлагагүй амьд үлдэгсэд ямар нэгэн тусламж үзүүлэх шаардлага бий болдог. Үүнд таних эд зүйлийг олох зорилгоор хувийн мэдээллийг тогтоох, гэр бүл, хамаатан садантай холбоотой мэдээллийг тогтоох ажил орно.

*Хариу үйлдэл үзүүлэгч болон албан хаагчийг халамжлах*

Онцгой нөхцөлийн хариу арга хэмжээний сэргээх үе шатанд олон нийтийн тусламж шаардлагатай байдаг. Хариу үйлдэл үзүүлэгч болон албан хаагч нь аэродромын осол зөрчлийн үед, ялангуяа, агаарын хөлгийн ослын үед мөн бэртэж гэмтэх магадлалтай.

Ослын талбайд ажиллаж байгаа бүх байгууллага нь тасралтгүй туслалцаа үзүүлэх болон ноцтой ослын дарамт, хямралыг арилгах мэргэжлийн туслалцаа авахад анхаарах шаардлагатай. Хохирчийг анхаарах, эсхүл энэ тохиолдолд салбарын сэтгэл зүйч нар ихэвчлэн шаардлагатай болдог.

*Ослын талбар руу эргэн нэвтрэх байгаа амьд үлдэгсэд болон хамаатан садныг халамжлах.*

Олон нийтийн тусламж үзүүлэх журам нь ослын талбар руу эргэж нэвтрэхийг хүссэн амьд үлдэгсэд болон хамаатан садны боломжийг анхаарсан байна.

### **А.6.3 Агаарын хөлгийг сэргээх төлөвлөгөө**

Агаарын хөлөг нь хөдөлгөөний бүсэд осолд орох, ХБЗ болон явгалах замаас гарах, шингэний даралт унах, дугуй хагарах техникийн доголдол, гэмтэл үүссэнээс болоод хөдлөх чадваргүй болох боломжтой. Агаарын хөлгийг сэргээх төлөвлөгөө нь хөдлөх чадвараа алдсан агаарын хөлгийг тодорхой хугацаанд ямар нэгэн цаашдын эвдрэл гэмтэлгүйгээр буюу тухайн бүсийг нислэгийн үйл ажиллагаанд аль болох түргэн оруулахын тулд шилжүүлэх ажлыг баталгаажуулсан байна.

Агаарын хөлгийг шилжүүлэн байрлуулах нь эцэстээ агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлага байдаг. Агаарын хөлгийг шилжүүлэн байрлуулахад оролцогч бүх байгууллагын зохицуулалт нь тусдаа журам болон боловсруулсан нөхцөлд энэ ажиллагааны үр дүн нь илүү сайжрах талтай. Журам нь АОНТ-ний нэг бүрдэл байх, эсхүл АОНТ-нд заасан тусдаа баримт бичиг байж болно.

Агаарын хөлгийг сэргээх төлөвлөгөө нь АОНТ шиг шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах үүднээс оролцогч байгууллагын үүрэг болон хариуцлагыг багтаасан, тэрчлэн энэхүү ажиллагаа эхлүүлэх холбооны системийг бүрдүүлсэн байна.

Дараах байгууллага хамрагдах боломжтой:

- аэродромын үйл ажиллагаа эрхлэгч
- агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч
- агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага
- нисэх буудлын аврах галын алба, эсхүл онцгой байдлын галын алба
- нисэхийн түлшний алба
- аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ үзүүлэгч
- тоног төхөөрөмжийн мэргэжилтэн, эсхүл бусад үйлчилгээ үзүүлэгчид

Үүн дээр нэмээд орон нутгийн нөөцийн жагсаалт буюу орон нутгийн нэмэлт хүчин, агаарын хөлгийг шилжүүлэх төхөөрөмжийн мэргэжилтний байршил, холбогдох ажилтантай холбоо барих тогтмол шинэчлэгдэж байдаг дугаар зэргийн хамт төлөвлөгөөнд орсон байна. Тоног төхөөрөмж байнгын бэлэн байдалд буй эсэх болон аэродром дээр нислэг үйлдэж буй агаарын хөлөгт таарах эсэхэд хяналт тавих, баталгаажуулах зорилгоор төлөвлөгөөг тодорхой хугацааны давтамжтайгаар тогтмол хянаж, шинэчилж байх шаардлагатай.

Шаардлагатай нөөцийн жишээ:

- агаарын хөлгийг чирэх болон өргөх төхөөрөмжийн мэргэжилтэн
- агаарын хөлгийн түлшийг соруулах төхөөрөмж
- өргөх болон татах цамхаг, эсхүл хэрэгсэл

Агаарын хөлгийн дугуй болон тоног төхөөрөмж явахад зориулсан замыг ухах төхөөрөмж

- ажлын тавцан, явах замыг сайжруулахад хэрэглэх хайрга, төмөр болон модон эдлэл
- агаарын хөлгийн эд анги, материалыг зөөх хүнд даацын тээврийн хэрэгсэл болон чиргүүл
- усан дахь агаарын хөлгийг аврах болон хөвүүлэх мэргэжилтэн
- нүүлгэн шилжүүлэх ажиллагаа харанхуйд явагдах үед хэрэглэх гэрэлтүүлгийн төхөөрөмж

Шаардлагатай материал болон төхөөрөмжийн дотоодын нөөц:

- талбай дээрх агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч
- талбай дээрх засварын үйлчилгээ үзүүлэгчид
- гэрээт компаниуд
- өргөгч цамхагийн оператор
- хүнд механизмын оператор
- аврах мэргэжилтэн
- хайрга болон гуалин банз модон бүтээгдэхүүн

Төлөвлөгөөг батлагдсан тохиолдолд сэргээх ажиллагааны удирдлагын төлөвлөлтөнд туслах зорилгоор төхөөрөмжийг талбай дээр бэлэн байлгахад зарцуулагдах хугацааг заасан байна.

#### **А.6.4 Хэвлэл мэдээллийн удирдлагын төлөвлөгөө**

Хэвлэл мэдээлэл болон олон нийтийн анхаарлыг Аэродромын онцгой нөхцөл, ялангуяа, агаарын хөлгийн осол маш ихээр татдаг. Мөн угтагчид болон үдэгчид онцгой нөхцөлийн талаарх мэдээллийг шаарддаг. Энэ төрлийн мэдээлэл нь тусгай хянах аргачлалаар сайтар зохицуулагдсан байна.

Онцгой нөхцөлийн дотоод нөхцөл, хэтийн төлөвийг тогтоох боломжтой ямар ч ажилтанд хэвлэл мэдээлэл хандах боломжтой. Нисэх буудал нь өөрсдийн холбогдох хэвлэл мэдээллийн багийг тодорхой, бодит мэдээллээр хангаснаар олон нийт болон бусад гадны хэвлэл мэдээллийн байгууллагыг цаг хугацааны хувьд шуурхай, нарийвчилсан мэдээлэл өгөх боломжийг олгодог.

Иймээс АОНТ-нд ямар нэгэн хязгаарлалтгүй, мэдээллийн авах хүсэлтийг хэрхэн зохицуулах, тарааж буй мэдээллийг баримтжуулах, холбооны сүвгийг сайжруулах, мэдээлэл түгээх байр болон мэдээлэгч, хэвлэлийн төлөөлөгчийг томилох зэргийг агуулсан холбогдох хэвлэл мэдээллийн төлөвлөгөөг оруулсан байхаар заагдсан. Хэвлэл мэдээллийн төлөвлөгөө нь АОНТ-ний нэг хэсэг, эсхүл тусдаа баримт бичиг байж болно.

Онцгой нөхцөлийн арга хэмжээ авах хугацааны туршид онцгой нөхцөлийг удирдах туршлагаар агаарын тээвэрлэгч болон аэродромын үйл ажиллагаа эрхлэгч бусад байгууллагын түслэмжтайгаар онцгой байдлын алба хэвлэл мэдээллийн асуудлыг хариуцна. АОНТ-ний хавсралт Хэвлэл мэдээллийн төлөвлөгөөнд дурдсан эрх бүхий/зөвшөөрөлтэй төлөөлөгчид мэдээлэл авах бүх хүсэлт очиж буй эсэхийг баталгаажуулна.

Хэвлэл мэдээллийн байгууллагыг тодорхой, бодит, шуурхай мэдээллээр хангаж ажиллах нь чухал юм. Маш олон агаарын тээвэрлэгчид агаарын хөлгийн осол гарсан газар төхөөрөмж байршуулах шаардлагатай бөгөөд Цагдаагийн газар ч бас зарим шаардлагатай хэрэгсэлтэй байна. Энэ тогтолцоо нь онцгой нөхцөлийн үед холбооны сүлжээг чөлөөтэй ашиглах боломжийг олгохоос гадна осолтой холбоотой бүх мэдээллийг зохицуулах боломж бүрдүүлдэг.

## Хавсралт В - Холбооны хэрэгсэл болон зохицуулалт

### В.1 Холбооны хэрэгсэл

Холбооны хэрэгсэл нь Аэродромын онцгой нөхцөлийн үеийн хамгийн чухал зүйл. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь АОНТ-нд заасны дагуу онцгой нөхцөлийн үед шуурхай хариу арга хэмжээг авахыг баталгаажуулсан байх үүрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэх гол асуудал бол шаардлагатай бүх хариу арга хэмжээ авах байгууллага болон хувь хүмүүсийг онцгой нөхцөлийн үе шатанд шуурхай сэрэмжлүүлэх явдал юм (АОНТ-г идэвхжүүлэх).

Хариу арга хэмжээ шаардлагатай байгууллага, эсхүл ажилтанд дуудлага өгөх дарааллыг АОНТ-нд тодорхой заасан байна. Тухайн онцгой нөхцөлийн үе шатыг цуцлах болон үүрэг бүхий байгууллагыг бэлэн байдлын горимд шилжүүлэх дараалал, үйл ажиллагааг мөн тусгасан байна.

Онцгой нөхцөлийн төрөл тус бүрээр анхны ослын дуудлага өгөх үүрэг бүхий ажилтныг тодорхой болгосон байна. Томоохон аэродромд НХУ-ын нэгж, аврах гал унтраах алба, аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон харъяа алба салбар байх нь түгээмэл байдаг. Нисэхийн аюулгүйн хамгаалалттай холбоотой онцгой нөхцөлийн үед Цагдаагийн газар болон ИНЕГ байж болох юм.

24 цагийн үйл ажиллагаа явуулдаггүй жижиг нисэх бүүдалд Цагдаагийн газар болон Гал унтраах алба онцгой нөхцөлийн түгшүүрийг зарлах болон холбогдох ажиллагааг эхлүүлнэ.

Онцгой нөхцөлийн түгшүүрийн систем ажиллагаатай эсэх, АОНТ-нд заасан утасны дугаар зөв эсэхийг тогтмол шалгаж баталгаажуулах шаардлагатай бөгөөд алдаа дутагдлыг илрүүлж холбогдох арга хэмжээг авна. Хуваарьт бус шалгалтын ажиллагаа нь өөр өөр оператор, өдрийн өөр цагт шалгах боломжийг олгодог.

Аэродромын онцгой нөхцөлийн түгшүүр зарлах ажиллагааг олон аргаар хийх боломжтой. Дараах аргыг ихэвчлэн хэрэглэдэг.

### В.2 Холбооны систем

#### В.2.1 Каскадын систем (төлбөргүй дуудлага)

Каскадын системээр онцгой нөхцөлийн түгшүүрийг идэвхижүүлэгчээс нэг удаагийн дуудлага бүлэг хүмүүс рүү хийгдэх бөгөөд онцгой нөхцөлийн түгшүүрийг зарлана. Дуудлага хүлээн авагч нь ирсэн мэдээллийг дуудлага өгөгчид дахин уншиж өгөх бөгөөд ингэснээр мэдээллийг хүлээн авсан болон зөв ойлгосон эсэхийг баталгаажуулдаг. Дуудлага хүлээн авсан хүмүүс нь онцгой нөхцөлийн үед өөрсдийн үүргийн дагуу доод түвшний хүмүүс рүү түгшүүрийн дуудлагыг дамжуулна. Энэ мэтчилэнгээр дуудлага Каскад буюу доош чиглэсэн дэс дараалалтайгаар жагсаалтанд байгаа бүх байгууллага болон ажилтанд бүрэн мэдээлэгдэх хүртэл үргэлжилнэ.

Салбарласан дуудлаганд /каскад/ байгаа байгууллага, эсхүл ажилтан нь онцгой нөхцөлийн үед авах хүлээн зөвшөөрөгдсөн арга хэмжээнд онцолсон байдлаар тодорхой түвшинд ангилагдсан байна. Нисэх бүүдлын аврах гал унтраах алба, онцгой нөхцөлийн галын алба, Цагдаагийн газар, түргэн тусламжийн үйлчилгээний онцгой нөхцөлийн албад нь каскадын системийн хамгийн дээд талд ямагт байна. Жагсаалтанд орсон байгууллага болон ажилтны авах арга хэмжээ нь зарласан онцгой нөхцөлийн үе шатын төрлөөс шалтгаалдаг. Онцгой нөхцөлийн зарим нөхцөлд бүх байгууллага оролцох албагүй бөгөөд харин зарим төрөлд тусгай мэргэжилтэн нэмэлт хэрэг болох талтай.



ИНД-139-ийн дагуу АОНТ-нд заасан байгууллага болон ажилтны холбогдох утасны дугаар, нэрсийг шинэчлэн засварлаж байх шаардлагатай.

Каскадын систем нь мөн зарим сул талтай. Онцгой нөхцөлийн үед ажиллах ёстой бүх байгууллага ажилтанд шаардлагатай мэдээлэл хүргэхийн тулд нилээд хугацаа шаардах бөгөөд, ялангуяа, дуудлага хүлээн авагч дуудлага өгөгчөөс ирсэн мэдээллийг үнэн зөв сонссон, ойлгосон эсэхийг нягтлахын тулд эргэж залгах, дахин унших, нягтлах ажилд маш их хугацаа зарцуулдаг.

Аэродром дээр гарсан агаарын хөлгийн осол маш ноцтой онцгой нөхцөлийн үед утсан холбооны сүлжээ хэт их ачааллаас болж мэдээллийг дамжуулах боломжгүй болох эрсдэлтэй.

Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн хороо нь холбооны үндсэн систем ажилгүй болсон, эсхүл саатсан үед мэдээлэл дамжуулах нөөц хувилбарыг тогтоосон байх шаардлагатай бөгөөд энэ талаар АОНТ-нд дурдсан байна.

### **В.2.3 Онцгой нөхцөлийн автоматжуулсан түгшүүрийн систем**

Онцгой нөхцөлийн автоматжуулсан түгшүүрийн систем нь (АТС) зориулалтын шугам, үүрэн холбоо, өгөгдөл/радио дамжуулах, урьдчилан бэлтгэгдсэн мэдээллийг олон тооны байгууллагад нэгэн зэрэг илгээх маш олон төрлийн дамжуулалтыг хийх чадвартай.

Эхлэн боловсруулагч нь мэдээллийн бичиглэл, эсхүл хуулбарыг автоматжуулсан түгшүүрийн систем рүү илгээдэг. Мэдээлэл АТС-рүү шилжмэгц системд холбогдсон бүх байгууллага руу автоматаар илгээгдэнэ.

Системийн төрлөөс шалтгаалж мэдээлэл хүлээн авагч нь компьютерийн дэлгэц дээр, цаасан хэвлэмэл байдлаар, гар утас, мэссэж, эсхүл дуут шуудангаар хүлээн авдаг байна.

Бичигдсэн дуут шуудан нь мэссэжийг хүлээн авсан даруйд хүлээн зөвшөөрөх хариу үйлдлийг шаарддаг. Илүү автоматжуулсан систем нь дэлгэцэн дээр мэдээлэл илгээгчийн хүлээн авсан, мэдээллийг хүлээн зөвшөөрсөн байдлыг үзүүлдэг.

АТС-ийн үндсэн давуу тал нь:

Мэдээллийг олон байгууллагад нэгэн зэрэг илгээх, хариу илгээх нийт хугацааг багасгах, операторт шаардлагат өөр үүрэгт ажлаа гүйцэтгэх боломж олгодог.

- Бусад нэмэлт байгууллага, дуудлага хүлээн авагчийг сүлжээнд нэмэх нь маш энгийн бөгөөд ялангуяа радио болон өгөгдөл болон зориулалтын бус шугам ашиглаж байгаа үед.
- Хэрэв АТС нь радио өгөгдөл дамжуулагч ашиглаж байгаа бол холбооны шугамын сүлжээний хэт ачаалал болон бусад асуудалд нөлөөлөхгүй.
- Зурвас мэдээлэл нь мэссэжийг бичиглэл хийх болон илгээсэн мэдээлэл нь эргэж уншиж баталгаажуулах хэрэгтэй бол илүү богино хугацааг шаарддаг.
- Мэссэжийг оффис болон машинд г.м олон байршилд хүлээн авах боломжтой.

АТС-ийн үндсэн сул тал нь

- Суурилуулах зардал
- Хэрэв үүрэн утас ашиглаж байгаа бол томоохон онцгой нөхцөлийн үед сүлжээний хэт ачаалал бий болох талтай.

### **В.2.4 Онцгой нөхцөлийн түгшүүрийн системийн мэдээллийн маягт**

Хэрэв мэдээлэл нь мессеж хэлбэрээр автоматаар илгээгдээгүй тохиолдолд нарийвчилсан мэдээллийг бичиж авах үүднээс хэрэглэх стандартын автоматжуулсан мэдээллийн системийн маягт нь байгууллагад тараагдсан байна. Энэ нь шаардлагатай бүх мэдээлэл өгөгдсөн болон холбогдох байгууллагад заасан шаардлагатай арга хэмжээг авах боломжийг бүрдүүлдэг.

Мэдээллийн шинж чанар нь онцгой нөхцөлийн төрлөөс хамаарч өөр хоорондоо адилгүй байх бөгөөд мэдээллийн маягт нь стандартчилагдсан байх нь чухал юм. Галын алба, түргэн тусламж нь өөр өөр байршилтай олон тооны аэродромоос онцгой нөхцөлийн дуудлага хүлээн авах байгууллагын нэгдсэн холбооны төвийн шаардлагыг баталгаажуулсан байна.

Аль байгууллага эхэлж дуудлага хүлээн авахыг үл харгалзан дараагийн мэдээлэл дамжуулахаас өмнө аль дуудлага нь хийгдсэн бэ гэдгийг тогтоох нь чухал байдаг.

Агаарын хөлгийн ослын талаарх мэдээллийн бүтцэд мэдээллийг дараах байдлаар эрэмбэлнэ:

- Оршил - ослын бус үед хэрэглэх, холбоо болон дадлагын зориулалтаар.
- Онцгой нөхцөлийн үе шат - агаарын хөлгийн осол, сүйрэл, бүрэн хэмжээний онцгой нөхцөл болон бэлэн байдлын үе шат.
- ХБЗ-ны байрлал - ослын байрлал, эсхүл агаарын хөлөг буулт үйлдэх ХБЗ.
- Агаарын хөлгийн төрөл.
- Буух тооцоот цаг.
- Ослын буулт үйлдэх шалтгаан, төлөв байдал.
- Агаарын хөлгийн зорчигч болон нисэх баг.
- Үлдэгдэл шатахууны хэмжээ /мэдэгдсэн үед/.
- Агаарын хөлөгт байгаа аюултай бараа.

Оршил, онцгой нөхцөлийн үе шат, дуудлагыг эргүүлж унших нь тусгай дөрвөлжинд тэмдэглэгдэх боломжтой. АТС-ийн мэдээллийн А загварыг Зураг 1 -ээр үзүүлэв.

Хэрэв шаардлагатай бүх мэдээлэл нь мэдэгдэх боломжгүй, эсхүл мэдэгдсэн бол мэдээллийн хамгийн чухал хэсгийг зарласан байвал зохино. Дээр үзүүлсэн мэдээллийн бүтэц нь мэдээлэл бүрийн хамгийн чухалчилж үзсэн бүрдэл бөгөөд чухал бүрдэл нь дарааллын эхэнд байрлах шаардлагатай.

Өмнө нь мэдээлэгдээгүй бүрдэл нь боломжтой болсон үед дутуу байсан мэдээллийг онцгой байдлын албадад дахин мэдээлнэ.

### *Байршил*

Аэродромын гадна үүссэн зөрчил, эсхүл аэродром нь захын дүүрэгт байрласан тохиолдолд, хариу үйлдэл үзүүлэгчид онцгой нөхцөлийн үед ашиглах тухайн орчны байршлын торлосон зургийг тарааж мэдээллийн дагуу зааварлана. Энэ нь тэдгээрт тухайн байршилд очиход газарзүйн янз бүрийн саад тотгороос зайлсхийн хамгийн найдвартай замаар очих боломжийг бүрдүүлдэг.

Хотын төвд байрласан аэродромын хувьд хотын захын орчмын байршлын зураг, гудамжны нэр г.м мэдээллээр онцгой нөхцөлд хариу үйлдэл үзүүлэх албадыг хангасан байна.

### *Агаарын хөлгийг таних*

Агаарын хөлгийг таних ажиллагаанд хэрэв тодорхой бол агаарын хөлгийн жингийн ангиллын мэдээллийг ашиглана. Гал унтраах алба нь агаарын хөлгийн төрөл, хэмжээнд тохирсон тооны

галын машиныг явуулах боломжтой. Хэдийгээр галын алба агаарын хөлгийг хүнд, хөнгөн, цэргийн гэж ангилсан байдаг боловч өөр аргачлалаар тогтоох үед эдгээр мэдээлэл нь чухал бус байдаг.

Боломжтой бол агаарын тээвэрлэгчийн нэр, агаарын хөлгийн дуудлага зэргээр мэдээллийг хангасан байна. Авах арга хэмжээний зорилго нь маш яаралтай биш боловч онцгой байдлын албадын үйл ажиллагаанд үнэтэй дэмжлэг болдог.

**Зураг 1 - Онцгой нөхцөлийн мэдээллийн маягтын загварын жишээ**

**Онцгой нөхцөлийн мэдээллийн маягтын загвар**

.....Нисэх буудлын онцгой байдлын алба

Оршил	(Зөвхөн онцгой нөхцөлийн бус үед ашиглах)
<input type="checkbox"/>	Дадлага (Гурван удаа хэлэх)
<input type="checkbox"/>	Холбоо шалгах (Гурван удаа хэлэх)

Үе шат

<input type="checkbox"/>	Осол	Осол	Осол
<input type="checkbox"/>	Бүрэн ОН	Бүрэн ОН	Бүрэн ОН
<input type="checkbox"/>	Бэлэн байдал	Бэлэн байдал	Бэлэн байдал

- а. ХБЗ-ны байрлал.....
- б. Агаарын хөлгийн төрөл.....
- в. Бүүх тооцоот цаг.....
- г. Ослын буулт үйлдэх шалтгаан, төлөв байдал.....
- д. Агаарын хөлгийн зорчигч болон нисэх баг.....
- е. Үлдэгдэл шатахууны хэмжээ.....
- ж. Агаарын хөлөгт байгаа аюултай ачаа.....

Эргэж унших	<input type="checkbox"/>
-------------	--------------------------

Хүлээн авсан цаг

Илгээсэн:	Байгууллага	Цаг
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....

## Аэродром дээрх бусад осол

Гал, аюулгүйн хамгаалалтын заналхийлэл, аюултай бодис асгарах, эмнэлгийн зэрэг аэродром дээрх бусад ослын үед шаардлагатай холбогдох мэдээлэл нь

- Ослын байршил
- Ослын төлөв байдал

Аэродромын онцгой нөхцөлийн үед ажиллах байгууллагыг АОНТ-ний мэдээлэл, эсхүл тусгай үйл ажиллагаа, журмын талаарх мэдээллээр хангах нь чухал. Бүх байгууллага нь тэдгээрийн тоног төхөөрөмж, машин механизмын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг АОНТ-нд оруулаагүй байх, эсхүл ослын талбар дээр гүйцэтгэх өөрсдийн үүргийг бүрэн мэдэхгүй байх магадлалтай. Үүнд онцгой нөхцөлийн тэргүүлэх байгууллага болох цагдаагийн газар, гал унтраах алба, түргэн тусламж хамгийн ойр байрлах нэгжийн авах шаардлагатай хариу арга хэмжээ орно.

Онцгой нөхцөлийн үед хамгийн түрүүнд хариу үйлдэл үзүүлэх нисэх буудалд ойрхон байрлалтай байгууллагад зориулан тусгайлсан хэсгийг аэродром дээр, эсхүл терминалын гадна, магадгүй шуудангийн салбарт бий болгоно.

### **В.3 Жижиг аэродромыг анхаарах**

Жижиг болон алслагдсан аэродром нь (нислэгийн талбайг оролцуулан) онцгой нөхцөлийн хариу арга хэмжээ авах ажилтангүй байж болох юм. Магадгүй аэродромыг мэдэхгүй болон түүний үйл ажиллагаатай танил биш хүмүүст найдах шаардлагатай болдог. Энэ нөхцөлд аэродромын нэр болон бодит байршлыг заасан, холбогдох шаардлагатай утасны дугаарыг хүний нэртэй нь хамт үзүүлсэн тэмдэгийг сайтар харагдахуйц газар байрлалуулсан байна.

### **В.4 Гуравдагч аэродром руу мэдээлэл өгөх**

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлгийн осол, зөрчлийн талаарх мэдээллээр хангах асуудлыг анхаарах бөгөөд хэрэв энэ нь агаарын тээврийн үйл ажиллагаа бол нислэг эхэлсэн болон очих аэродромын үйл ажиллагаа эрхлэгчдийг ослын талаарх мэдээллээр хангана. Ерөнхийдөө энэ нь агаарын тээвэрлэгчээр дамжуулагдах боловч тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээнээс мөн хамаарах тул аэродромын үйл ажиллагаа эрхлэгч мэдээллийг шаардлагатай хугацаанд бас мэдээлнэ.

Энэ нь гуравдагч аэродромын үйл ажиллагаа эрхлэгчид өөрсдийн аэродром дээр угтагсад болон үдэгсэд, хамаатан садан, хэвлэл мэдээлэл зэрэгтэй холбогдох арга хэмжээ авах боломжийг олгоно. Жнь: агаарын хөлөг хөөрөөд удаагүй байхад гарсан осол. Телевизийн нэвтрүүлгээр цацагдаж буй ослын талаарх өргөн хүрээний хэвлэл мэдээллийн дүрс бичлэгээс ослын эсрэг арга хэмжээг авна. Энэ арга хэмжээг мөн аэродром дээр хүлээж байгаа хамаатан садан телевизээр үзсэн. Тухайн аэродром дээрх агаарын тээвэрлэгчийн ажилтан болон аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь ямар ч бэлтгэлгүй байсны улмаас шаардлагатай арга хэмжээг зохих ёсоор авч чадаагүй. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч ослын мэдээлэл дамжуулах талаар ослын үеийн стандарт, журамд оруулсан байна.

### **В.5 Зохицуулалт**

АОНТ нь Аэродромын онцгой нөхцөлийн үе шатанд хариу арга хэмжээ авах байгууллага болон ажилтны үр дүнтэй уялдаа холбоог хангах. Онцгой нөхцөлийн үе шат бүрд тодорхой

байгууллага, хувь хүмүүс онцгой нөхцөлийн ерөнхий хариу арга хэмжээний чухал бүрэлдэхүүн хэсгийг гаргаж өгөх болно.

ICAO Doc 9137 - Нисэх буудлын үйлчилгээний гарын авлага Хэсэг 7, Бүлэг 3 болон 4, Нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн баримт бичиг нь байгууллагын онцгой нөхцөлийн үе шатанд гүйцэтгэх үүрэг болон холбогдох албадыг дурдсан болно. Байгууллага болон ажилтны гүйцэтгэх үүргийг тодорхой болгож АОНТ-нд заасан байна.

Цагдаагийн газар болон Гал унтраах алба, Түргэн тусламжийн байгууллага нь онцгой нөхцөлийн шүүрхай хариу авах арга хэмжээг ихэвчлэн удирдан явуулдаг. Халдварт өвчин зарим нэгэн онцгой ажлыг тухайн дүүргийн Эрүүл мэндийн байгууллага удирдан явуулна.

### **В.5.1 Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем (ЗУЗС)**

Ослын үед байгууллага хоорондын ажиллагааг сайжруулах үүднээс онцгой байдлын алба нь Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем (ЗУЗС) нэртэй онцгой нөхцөлийн хариу арга хэмжээний загварыг гаргасан. Энэхүү загвар нь тэдгээр байгууллагын онцгой нөхцөлийн үеийн хамтарсан ажиллагааг стандартчилсан болно. ЗУЗС нь онцгой нөхцөлийн үеийн удирдлага, хяналт, зохицуулалтын загвар юм.

Энэ нь ямар ч хэмжээний онцгой нөхцөлийг удирдах болон оролцогч байгууллагын үүрэг, хариуцлага, зохицуулалтын дүрмийг тодорхойлдог.

ЗУЗС нь дараах зүйл дээр үндэслэнэ:

- Удирдлагын нэр томъёо
- Байгууллагын бүтэц
- Нэгдсэн холбоо
- Нэгтгэсэн зөрчлийн арга хэмжээний төлөвлөгөө (АОНТ)
- Удирдлагын хир хэмжээ
- Зөрчлийн удирдлагын цэг болон онцгой нөхцөлийн удирдлагын төвийг оролцуулсан төхөөрөмж байгууламж
- Нийт нөөц эх үүсвэрийн удирдлага

Онцгой нөхцөлийн цар хүрээнээс хамаарч ЗУЗС нь үндсэн 4 хүчин зүйл дээр тулгуурлана:

- Хяналт - зөрчлийн удирдлага
- Төлөвлөлт болон шийдвэрлэлт - ослын мэдээллийг цуглуулах болон дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээг төлөвлөх
- Үйл ажиллагаа - ослын нөхцөлд тохируулан байгууллагын нөөцийг чиглүүлэх
- Логистик - ослын нөхцөлд тохирсон хэрэгцээт байгууламж, тоног төхөөрөмж, материал, үйлчилгээний шаардлага

Ослыг хянах нь ослын хяналтын ажилтны үүрэг хариуцлага юм. Ослын хяналтын ажилтанд дараах шаардлагыг тавина:

- Удирдлага болон хяналтыг тогтоох
- Зөрчлийн удирдлагын цэгийг тогтоох
- Хүний амь болон эд хөрөнгийг хамгаалах
- Хүмүүс болон тоног төхөөрөмжийг хянах
- Хариу үйлдэл үзүүлэх байгууллага тооцоотой байх онцгой нөхцөлийн үндсэн үүргийг биелүүлэхээс гадна нийтийн аюулгүй байдлыг хангах

- Онцгой нөхцөлийг арилгах үйл ажиллагаа эхэлсэн үед гадны байгууллага болон Онцгой нөхцөлийг удирдах төвтэй холбоотой ажиллах.

Дараах ажил маш чухал:

- Байгууллагын хооронд хэвтээ байдлаар ажилладаг болон тухайн нөхцөл байдалтай холбоотой ослын хяналт
- Байгууллагын хооронд босоо байдлаар үйл ажиллагаа явуулдаг удирдлагын шугам

Зөрчлийн талбарт зөвхөн 1 ослын хянагч байх боловч олон байгууллага оролцохын хирээр олон тооны удирдлагын шугам байдаг.

Зөрчил өсөхийн хирээр ослын удирдлагын цэг, онцгой нөхцөлийн удирдлагын төвийг байгуулсан байна.

- Нөөц эх үүсвэр ослын талбар, эсхүл аюулгүйн цэг руу очихоос өмнө нэг дор цугларах бүсийг Цугларах бүс гэнэ.
- Зөрчилд ойрхон байрлах, тодорхой аюулгүйн зайнд үйл ажилаагааны тусламж үзүүлэх боломж бүхий бүсийг Аюулгүйн цэг гэнэ.
- Ослын талбар нь байгууламжаас хол, нөөц эх үүсвэрийг бэлтгэх, тарааж байршуулах бүсийг Цугларах бүс гэнэ.

### **В.5.2 Онцгой нөхцөлийн удирдлагын төв**

*ИНД-139.57 (b)5*

Олон улсын нисэх буудал нь онцгой нөхцөлийн удирдлагын төвтэй байхыг дүрэмд шаардсан байдаг.

ОНУТ нь осол, зөрчлийн хяналтын ажилтанд туслах зорилготой аэродром дээрх суурин байгууламж юм. Хэдийгээр ноцтой ослыг мэдээлсэн үед аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн байгууламж нь бэлэн байх шаардлагатай ч томхон хэмжээний онцгой нөхцөлийн үед энэ байгууламж идэвхиждэг.

Энэ нь онцгой нөхцөлийн дотоодын хяналтын ажилтны байрлалыг тодорхойлно. Дотоодын хяналтын ажилтны үйл ажиллагаа нь ихэвчлэн тэргүүлэх байгууллагын нэг болох Цагдаагийн газраас хийгддэг бөгөөд (хэдийгээр бүгдэд нь биш боловч) нисэх буудлын бүсийн гадна ч үйл ажиллагаа явуулдаг. АОНТ-нд онцгой нөхцөлийн арга хэмжээ авахаар төлөвлөсөн тохиолдолд тэргүүлэн гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагыг тодорхойлсон байна.

Хариу үйлдэл үзүүлэх зохицуулагч талбай дээр байхгүй үед онцгой нөхцөлийн үйл ажиллагааны төв нь ОНУТ нь зохицуулагчид аэродромын мэдээлэл болон нөөц эх үүсвэрийн удирдлагын төв болж ослын талбарт хариу үйлдэл үзүүлэх зохицуулагчийг мэдээллээр хангана. ОНУТ нь холбоо, захиргаа, үйлчилгээний байгууламжийг байгуулсан байна.

### **В.5.3 Зөрчлийн удирдлагын цэг (ЗУЦ)**

*ИНД-139.57(b)(5)*

Олон улсын аэродром нь онцгой нөхцөлийн төрөл бүрд төлөвлөсөн удирдлагын цэгтэй байхыг дүрэмд шаардсан байдаг.


ИКАО-гийн баримт бичигт ЗУЦ-ийг хөдөлгөөнт байхаар зөвлөдөг. Энэ нь бас ЗУЦ гэж нэрлэгдэнэ.

Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем (ЗУЗС)-ийн хандлагыг байгуулахад аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь (олон улс болон орон нутгийн үйл ажиллагаа гэхгүйгээр) АОНТ-нд төлөвлөгдсөн онцгой нөхцөл бүрийг тооцсон ЗУЦ-ийг тодорхойлох хэрэгтэй.

Зөрчлийн удирдлагын баг нь мэдээллийг хүлээн авах болон тараах мөн ослын удирдлагын төвөөс хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэрийг гаргаж ажилладаг. ЗУЦ нь тээврийн хэрэгсэл буюу хөдөлгөөнт, чиргүүлэн, майхан, барилга, түр байгууламж хэлбэрээр байж болох юм.

ЗУЦ нь цаг агаарын хүчин зүйлээс сэргийлж хаалт, халхавчтай, маш тодорхой байгуулагдсан байвал зохино. Зөрчилтэй холбоотой дуу чимээ, эргэлзээ төрүүлэхүйц зүйлээс хол, бодит болон боломжит аюултай бүсээс хол байрласан байна.

ЗУЦ рүү орох нь хяналттай байх бөгөөд нийтийн хөдөлгөөний бүсээс хол байрлах шаардлагатай. АОНТ-нд ЗУЦ-ийг хаана хэрхэн байршуулахыг заасан байна.



Зураг2 - Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем (ЗУЗС)-ийн схем зураг



## Хавсралт С - Эмнэлгийн анхаарах зүйлс

### С.1 Эмнэлгийн төхөөрөмж

#### ИНД-139.57(b)(6)

АОНТ-нд онцгой нөхцөлийн үед хэрэглэх шаардлагатай төхөөрөмж болон эмнэлгийн төхөөрөмжийг багтаасан байршлыг тодорхойлсон байна.

Эдгээр хөрөнгийн тоо хэмжээ болон эмнэлгийн төхөөрөмж нь тухайн аэродром дээр тогтмол нислэг үйлддэг хамгийн том зорчигч тээврийн агаарын хөлөгт дүйцсэн байхаас гадна онцгой нөхцөлийн үед шаардлагатай хугацаанд ослын талбай дээр байх шаардлагатай.

Аврах, гал унтраах үйлчилгээгүй жижиг аэродром. Эмнэлгийн анхан шатны тусламжийн хэрэгсэл терминал дотор байх шаардлагатай.

Аврах, гал унтраах үйлчилгээтэй орон нутгийн аэродром. Зориулалтын анхны тусламжийн өрөө байх шаардлагатай.

Аврах, гал унтраах ажилтан нь анхны тусламж үзүүлэх сургалтанд хамрагдсан, аврах гал унтраах тээврийн хэрэгсэлд болон терминал дотор шаардлагатай анхны тусламжийн хэрэгслийг байршуулсан байна.

Олон улсын аэродром. Эмнэлгийн тусламжийн хэрэгслийн төвшин нь нислэг үйлддэг агаарын хөлгийн төрөл болон хэмжээнд дүйсэн байна. Хамгийн багадаа аврах гал унтраах тээврийн хэрэгсэлд болон терминал дотор шаардлагатай анхны тусламжийн хэрэгслийг байршуулсан байна. Мөн сайтар тоногдсон эмнэлгийн төхөөрөмж нь чиргүүлэн болон бага оврын тээврийн хэрэгсэл байх боломжтой бөгөөд ямар ч онцгой нөхцөлд хэрэглэгдэх боломжтой байвал зохино.

Маш олон төрлийн эмнэлгийн төхөөрөмж нь хугацаа дуусдаг учир хадгалахад яг аль нь хадгалагдах вэ гэдэг нь асуудалтай байх магадлалтай. Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн Хороо нь юуг хадгалах нь зохимжтой вэ гэдгийг тогтоох зорилгоор эмнэлгийн зөвлөх болон зохицуулагчийг ажиллуулах талаар анхаарах хэрэгтэй. Орон нутгийн түргэн тусламж нь шаардлагатай үед туслах боломжтой байна.

Зарим аэродром эмнэлгийн холбоотой эргэлтийн хөрөнгө нь аэродром дээр хугацаа хэтрэхгүй гэдгийг баталгаажуулах зорилготой орон нутгийн түргэний албатай хамтран ажилладаг. Түргэн тусламжийн хэрэгслийг битүүмжилсэн саванд хадгалах, эмнэлгийн туслах хэрэгслийн эргэлтэнд оруулах арга хэмжээ авдаг. Энэхүү тогтолцоог нэвтрүүлснээр хэрэгслийг зохистойгоор зохицуулах боломж бүрддэг.

Контейнерт хадгалсан эмнэлгийн хэрэгсэл нь нисэх буудлын гадна үүссэн осол, эсхүл саадтай зам болон олон төрлийн янз бүрийн замаар хялбар тээвэрлэж болдог.

Хүчилтөрөгчийн баг, бортого, хөнжил, дамнуурга нь онцгой нөхцөлийн тээврийн хэрэгслээр олон тоогоор зөөвөрлөхөд тохиромжгүй юм.

### С.2 Ангилах болон эмнэлгийн тусламж

ICAO. Doc. 9137 - " Нисэх буудлын үйлчилгээний гарын авлагын 7-р хэсэг, нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөлт, бүлэг 9,10,13 баримт бичигт нийтээр осолд нэрвэгдсэн гарз хохирлыг тооцсон Аэродромын онцгой нөхцөлийн эмнэлгийн холбоотой асуудал, түүний удирдлага зохицуулалтыг өргөн хүрээтэйгээр дурдсан болно. Нийтээр осолд нэрвэгдсэн үед эхлээд ослын

талбайгаас аюулгүй ангилах бүсэд гаргах, дараа нь эмчилгээний бүс, дараа нь тээвэрлэх бүсэд аваачаад эцэст нь эмнэлэг болон эмчилгээний төхөөрөмж бүхий газарт зөөвөрлөх зэргээр өөрчлөгддөг. Энэ аргачлалыг эмнэлэг, түргэн тусламж дагаж мөрдөх ба зөрчлийн удирдлагын зохицуулагдсан системд нийцсэн байна. Ангилах бүсэд эмнэлгийн анхны үзлэг, тусламжийн дараа хүмүүст шошго болон түүнтэй ижил зүйл зүүлгэн түүгээр нь гэмтлийн зэрэглэлийг ил болгоно. Өвчтөний шилжилт хөдөлгөөнийг мөн системийн тусламжтайгаар таних, бүртгэх ажилаагааг хэрэгжүүлдэг. Нийтийг хамарсан осол сүйрлийн үед түргэн тусламжийн ослын удирдлагын төвийн шийдвэрээр дээр дурдсан шошгыг хэрэглэнэ. Түргэн тусламжийн үйлчилгээний төв нь шошгийг нөөцөлсөн байна.

Зэрэглэл тогтоох, эмнэлэг, эсхүл бусад эмнэлгийн төхөөрөмж рүү тээвэрлэхэд гэмтэгсдийн тоо, эмчилгээний дэс дараалал тогтоох зэргээс шалтгаалаад саатал үүсэх магадлалтай. Амь наснаас хол, алхах боломжтой г.м гэмтэл бүхий хүмүүсийг эмнэлэг рүү тээвэрлэх талбайд хүлээлгэх боломжтой.

Энэ хугацаанд тэдгээр хүмүүст анхаарал тавих, бүрэн хэмжээний зохион байгуулалттай ажилд туслах зорилгоор холбогдох мэдээллийг цуглуулах ажил хийгдэнэ.

Онцгой нөхцөлийн журмын “Нийгмийн халамжийн” тусламжийн төлөвлөгөөний дагуу ажиллах тусдаа багийг авчирсан байна.

### **С.3 Амьд үлдэгсдийг халамжлах**

Түргэн тусламжийн үйлчилгээ болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллага нь нийтийг хамарсан ослын талбарт амьд үлдэгсдийг анхаарах асуудлыг зохицуулах төлөвлөгөөтэй байна. Гэвч Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн хороо нь ослын талбайд “Нийгмийн халамжийн төлөвлөгөө” хэрэгжих үед хэрэглэх боломжтой ямар эх үүсвэр, нөөц бэлэн байгаа эсэхийг анхаарна.

Олон хүн хамарсан ослын тохиолдолд явган явах боломж бүхий шархадагсад түр хүлээх талбай байгуулсан байхыг шаардах, эсхүл эмнэлгийн тусламж аваагүй хүмүүсийг холбогдох эмнэлгийн тусламжийн байгууламж руу илгээхийн өмнөх хүлээлгэх талбайд байна.

Иймэрхүү хүлээлгэх талбай нь нийтийн бүсээс тусгаарлагдсан, хаалт болон дулаан нөхцөлийг аль болох сайтар бүрдүүлсэн, хамгаалалттай байна. Ялангуяа хаалт хамгаалалт болон дулаан орчин нь маш чухал учир зорчигчийн терминал, ангар болон бусад барилгын доторх талбайг ашиглахаар төлөвлөх нь зүйтэй. Хэрэв энэ нь боломжгүй бол талбайгаас тээвэрлэх болон тээврийн хэрэгсэл ашиглаж хаалт хамгаалалтыг орлуулан түр хүлээх байгууламжийг байгуулах, эсхүл үүссэн нөхцөл байдлаас тайвшрахад хэрэглэх нь зүйтэй.

Ослын талбар дээр болон талбараас олон тооны амьд үлдэгсдийг зөөж тээвэрлэх талаарх заалт, шаардлагыг боловсруулсан байна. Үүнд нийтийн тээвэр, ялангуяа, автобусыг хамгаалах асуудал хамрагдана.

Ослоос амьд үлдсэн бүх хүмүүсийг тэдгээрийн нөхцөл байдлыг үл харгалзан эмнэлэг болон эмнэлгийн тусламжийн байгууламж руу тээвэрлэх ёстой.

Хэдийгээр агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг боловч гадны улсад нислэг үйлдэж байсан нисэх багийн эсрэг хүчирхийллийн тохиолдлын журмын дагуу нисэх багийг бусад зорчигчдоос тусгаарласан байна.

#### **С.4 Амь үрэгдэгсдийн асуудлыг зохицуулах**

Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн хороо нь Цагдаа болон эмнэлгийн байгууллага ослын талбай дээр цогцос хадгалах түр зуурын байгууламж байршуулсан байх боломжийг анхаарна.

Цагдаагийн байгууллага, эсхүл холбогдох байгууллага зөвшөөрөх хүртэл цогцосыг ослын талбайгаас зөөвөрлөхгүй байна. Нөхцөл байдлаас шалтгаалаад сүйрлийн хохирогчдийг тогтоох ажиллагааны мэргэжилтний баг мөрдлөг шалгалтын ажиллагаа явуулах, бие болон биеийн хэсгийг шилжүүлэхийн тулд талбай дээрх эд мөрийн баримтын бичлэгийг хийх шаардлагатай байдаг.

Орон нутгийн цогцос хадгалах байгууламж нь олон тооны амь үрэгдэгсдийн цогцсыг хадгалах боломжгүй бол Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн хороо нь АОНТ-нд боломжтой байрлалыг тогтоосон бана. Энэ нь орон нутгийн эмнэлгийн байгууллагын хамтран ажиллах талбай болно. Заасан талбайд хөргөлтийн тоноглол бүхий агуулах, контейнер байхгүй бол орон нутгийн тээврийн байгууллага, хөргөлтийн тоног төхөөрөмжийн дэлгүүрээс авах нь зүйтэй.

## Хавсралт D - Бодит нөхцөлд ойртуулсан онцгой нөхцөлийн дасгал сургуулилт

ИНД-139.109

### D.1 Зорилго

Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь АОНТ-нд дурдсан бэлэн байдлыг хангах талаарх шалгалтыг явуулах зорилгоор бодит байдалд ойртуулсан онцгой нөхцөлийн дасгал сургуулилтыг тогтмол явуулах ёстой.

Энэ нь дараах үйл ажиллагааны аль нэгээр дасгал сургуулилтыг явуулна:

- (a) Онцгой нөхцөлийн бүрэн хэмжээний дасгал сургуулилт нь хамгийн багадаа 2 жил тутамд 1 удаа, үүгээр илэрсэн дутагдлыг арилгаж сайжруулсан эсэхийг баталгаажуулах зорилгоор бүрэн хэмжээний дасгал сургуулилтын тодорхой хэсгийн сургуулилт
- (b) (b) жил тутамд хийгдэх загварчилсан цуврал шалгах сургуулилт, энэхүү цуврал шалгалтыг эхлүүлсэн эхний жилээс хойш 3 жилээс илүүгүй хугацаанд бүрэн хэрэгжүүлж дуусгана.

Илэрсэн дутагдал дээр үндэслэн тусгай дасгалын хүрээ болон хэмжээг гаргах бөгөөд шалгах тохируулах ажлыг мөн хийнэ.

Загварчилсан шалгалт нь тодорхой хэсэг дээр төвлөрч болох боловч дараах хязгаарын хүрээнд байна:

- Мэдээлэх + онцгой нөхцөлийн холбоо + түгшүүрийн дохио өгөх + уулзах цэг (УЦ) + бэлэн байдал
- Нисэх буудлын галын алба + онцгой байдлын галын алба + тактикийн дасгал сургуулилт + ослын талбайн эд мөрийн баримтыг хамгаалах + үйл ажиллагааны аюулгүй байдал (ослын талбай дээр)
- Зөөвөрлөх дасгал + гэмтэгсдийг зохицуулах + ангилах + эмнэлгийн тусламж + түргэн тусламж
- Зөрчлийн удирдлагын зохицуулагдсан систем (ЗУЗС), удирдлага ба хяналт + удирдлагын цэг + нисэх буудлын Онцгой нөхцөлийг зохицуулах төв
- Тээвэрлэлт / төхөөрөмж
- Ослын дуудлага хүлээн авагч + найз болон хамаатан саданг байрлуулах + агаарын хөлгийн нисэх багийг байрлуулах + хэвлэл мэдээлэл
- Хэвийн ажиллагааг үргэлжлүүлэх + үйл ажиллагааны аюулгүй байдал
- Агаарын хөлгийг сэргээх + хэвийн үйл ажиллагаанд орох + мөрдлөгө шалгалт + ослын дараах тайлан мэдээлэл

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь ширээний сургалт, онцгой нөхцөлийн уулзалт, хурал, эсхүл бусад цагт нь багийн хэлэлцүүлэг г.мийг багтаасан нэмэлт дасгал сургуулилтанд анхаарал хандуулах. Жнь:

- 2003 оны CAPS, 2014 оны Эбола г.м олон улсад тархах магадлалтай халдварт өвчин
- Зорчигч үйлчилгээний шинэ барилга г.м аэродром дээрх томоохон өөрчлөлт
- Галын албаны болон түргэн тусламжийн авах арга хэмжээг ангилах байгууллагын тусгай дасгал

- Байгууллагын бага хэмжээний сургуулилт ялангуяа сайн дурын болон ээлжийн ажилтантай бол хийх. Энэхүү ажиллагаа нь АОНТ-нд заасан хүмүүсийг аль болох олноор нь сургаж, дадлагажуулах боломж олгодог.

## **D.2 Бодит нөхцөлд ойртуулсан онцгой нөхцөлийн дасгал сургуулилт**

Аэродромын онцгой нөхцөлийн сургалтын зорилго нь дараах нийцлийг шалгана:

- Оролцогч бүх ажилтны үүрэг, хариуцлага
- Онцгой нөхцөлийн журам болон үйл ажиллагаа
- Онцгой нөхцөлийн төхөөрөмж болон холбооны хэрэгсэл

### **D.2.1 Онцгой нөхцөлийн дасгал сургуулилтын бэлтгэл**

Онцгой байдлын албанаас тогтмол зохион байгуулдаг дасгал сургуулилтын талаарх мэдлэг, үр чадвар дээр үндэслэн онцгой нөхцөлийн дасгал сургуулилтын бэлтгэх.

Онцгой нөхцөлийн дасгал сургуулилтын явц, хэрхэн дуусах зэргийг хариуцсан ерөнхий удирдагчийг томилох хэрэгтэй. Томхон хэмжээний дасгал сургуулилтанд өөрсдийн холбооны системийн шаардлага, удирдлагын сүлжээ бүхий тусгай баг ажиллах тохиолдол байдаг. Багийн бүрэлдэхүүнд ерөнхий хариу үйлдлийг хянах өөр газар байрладаг дасгалын шүүгч болон аюулгүй байдлын ажилтнууд багтана.

### **D.2.2 Онцгой нөхцөлийн дасгал сургуулилтын хүрээ**

Дасгал сургуулилтын өмнө, Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн хороо нь АОНТ-ний шалгах шаардлагатай хэсэг, бүрдэл болон хэмжигдэх боломжтой зүйлсийг тогтоох шаардлагатай. Энэ нь дасгал сургуулилтын хамгийн зөв хувилбарыг боловсруулахад тусална. Хороо нь дасгал сургуулилтын үед судлах, боловсруулах бүрдэлд хязгаарлалт хийх бөгөөд судалгааны орчныг сайтар бүрдүүлэх болон хамгийн хэрэгтэй зүйлсийг олох боломжийг анхаарна. Олон төрлийн хэт их хэмжээний дасгал сургуулилт нь оролцогчдийг ядраах, эргэлзээнд оруулах магадлалтай.

Тодорхой ажиллагаа болон байгууллагад зориулсан хэсэгчилсэн сургалтыг явуулах аргыг хэрэглэж болно. Энэ нь ширээний дасгал, авах арга хэмжээг шалгах, биечлэн гүйцэтгэх дадлага г.м байж болно.

Ширээний дасгалаар өрөөнд нисэх буудлын байршлын зураг болон өгөгдсөн дарааллын дагуу оролцогчдын авах арга хэмжээг тусгайлан бэлтгэсэн самбар дээр хэлэлцэх зэргийн аль ч аргыг хэрэглэн явуулах боломжтой болно. Энэ нь онцгой нөхцөлийн үед ажиллах албадын ердийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр мөн ямар нэгэн зардалгүйгээр онцгой нөхцөлийн нөөц, эх үүсвэрийн боломж, хүчин чадал, хамтын ажиллагаа зэргийг шалгах үед хэрэглэгддэг.

Ширээний дасгалын дараагийн түвшин нь дасгалыг нэгбүрчлэн нягтлах ажиллагаа юм. Энэхүү дасгал нь талбай дээр хийгддэг бөгөөд хугацаа алдан удаашрах байдлыг засах, хэвшүүлэх, дасгалжилтын ямар ч үеийн үйл явдлын үр дүнг зогсоох боломжийг бүрдүүлэх, оролцогч байгууллага болон ажилтны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой.

Бүрэн хэмжээний дасгал сургуулилт талбай дээр явагдах бөгөөд өгөгдсөн онцгой нөхцөлийн зохиомжийн дагуу хариу арга хэмжээг бүрэн авах дасгал хийгдэнэ. Дасгалжуулалтын өгөгдсөн хэмжээний дагуу зарим нисэх буудал нь онцгой нөхцөлийн үе шат болон Сэргээх үе шат гэсэн 2

үе шаттайгаар буюу 2 тодорхой үе шаттайгаар дараалсан 2 өдрийн турш бүрэн хэмжээний дадлагажуулалтыг хийдэг. Энэ нь АОНТ-ний чухал хяналт, үнэлгээг хийхэд тусалдаг.

### **D.2.3 Онцгой нөхцөлийн дасгал сургуулилтыг төлөвлөх, хугацааг тогтоох**

Олон төрлийн онцгой нөхцөлийн үе шатны дадлагын хөтөлбөр болон хугацааг тооцоход анхаарах шаардлагатай. Онцгой нөхцөл байдлын зохиомжийн дагуу шөнийн цагт онцгой нөхцөлд хариу арга хэмжээ авах нь өдрийн гэрэлтэй цагт авахаас нилээд хэцүү төвөгтэй зэргийг тооцож сургуулилтын хөтөлбөр болон хугацааг төлөвлөх хэрэгтэй. Энэ нь хүмүүсийн тоо цөөрсөн үйл ажиллагааны оргил ачааллын бус цаг учир ажилтны нөөцийн түвшинг төвлөрүүлэх шаардлага гарна. Дасгал сургуулилтыг агаарын хөлгийн нислэгийн цагийг харж өглөө эрт, орой, шөнө г.м аль болох цонхтой цагт хийх хэрэгтэй. Эдгээр цагт осол сүйрэл тохиолдох илүү магадлалтай учир хийх дасгалын үр дүн нь бодит байдалд илүү ойрхон болно. Энэ нь онцгой байдлын албадын хамгийн бага ажилтантай үе, замын хөдөлгөөний ачаалалтай үе, ээлжийн ажилтны ээлж солилцох үед үүссэн тээвэрлэлтийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд илүү амар болгодог.

### **D.2.4 Оролцогсдод зохицуулалт хийж үр дүнг нэмэгдүүлэх**

Дараагийн анхаарах асуудал нь дасгал сургуулилтын үед бүх байгууллагын авах хамгийн зохистой арга хэмжээг баталгаажуулах юм. Онцгой нөхцөл нь олон цагийн турш болон хэдэн өдөр ч үргэлжлэх боломжтой. Хүмүүс олон цагийн турш зохих түвшинд тасралтгүй ажиллах боломжгүй тул ажилтныг шаардлагатай үед амрах нь зүйтэй бөгөөд орлох ажилтныг ослыг үргэлжлүүлэн арилгахад голлох үүрэг бүхий байршилд ажиллахаар төлөвлөсөн байна. Онцгой нөхцөлийн дасгал сургуулилтанд оролцож байгаа байгууллага нь шаардлага гарвал уртасгасан цагаар ажиллах боломжтой болохоо үзүүлэх үүрэгтэй.

### **D.2.5 Бусад анхаарах зүйл**

Зорилтоо тодорхойлох болон АОНТ-г нягтлах бодит зохиомжийг боловсруулах үед аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн хороо дараах асуудлыг анхаарна:

- аэродромын өөрийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх чадвар;
- сайн дурынхан болон ажилтнуудаас оролцогчдын эрүүл мэнд болон аюулгүй байдал;
- хамтран ажиллах байгууллага, холбоо, ялангуяа, урьдчилан ажилладаг байгууллага;
- даатгалын хамрах хүрээ;
- зохиомжинд агаарын тээвэрлэгч болон зорчигчийн зохиомол нэрийг ашиглах;
- ажиглалтын байршлыг бэлтгэх, дадлага сургуулилтын дараа ажиглагчийн шүүмж бичих хуудсыг бэлтгэх.

Сургуулилтын үед үүсч болох онцгой нөхцөлийн бодит байдалд авах арга хэмжээг гаргах г.м.

## **D.3 Дасгал сургуулилтын дараах тайлан**

*ИНД-139.109(3)*

Онцгой нөхцөлийн дасгал сургуулилтын дараа оролцогч байгууллага болон зорчигч, угтагсад, үдэгсэд болон жүжиглэсэн сайн дурынхны сэтгэгдлийг сонсох үүднээс дасгал сургуулилтын дараах үр дүнгийн тайланг гаргана. Дасгал сургуулилтын үед хэрхэн аврагдсан болон зохион байгуулалтын талаар сайн дурынхны сэтгэгдлийг сонсох нь үнэтэй зөвөлгөө болдог.

Дасгал сургуулилтын үед аль хэсэг нь сайтар хэрэгжсэн, аль хэсэг нь сайжруулах шаардлагатай болон зорилгодоо хүрсэн эсэх талаар томилогдсон ажиглагчаас шүүмжийн хуудсын дагуу санал хүсэлтийг нь авах шаардлагатай.

Бүх байгууллага ажилчдынхаа талаар мэдээлэл хийж, аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн хороонд өгөх тайлан бэлтгэхийг уриалах хэрэгтэй. Хороо тайланг хүлээн авмагцаа тайланг дүгнэх, нягтлах, хэлэлцэх болон АОНТ-нд өөрчлөлт оруулах зөвлөмж гаргах талаар бүрэн хэмжээний үр дүнгийн тайлан хурлыг зохион байгуулна.

## Хавсралт Е - Бусад анхаарах асуудал

### Е.1 Угтагсад болон гашуудагсдыг зохицуулах

#### Е.1.1 Угтагсад болон гашуудагсад

Ирж буй болон явах нислэгийн зорчигчидтэй уулзахыг хүссэн хамаатан садан, найз нөхөд, ажлын хамтрагч хүмүүстэй ажиллах нь агаарын хөлгийн ослын үед авах арга хэмжээний нэг юм.

Ерөнхийдөө эдгээр хүмүүсийг “угтагсад болон гашуудагсад” гэж тодорхойлдог. Хэдийгээр өмнө энэ талаар А 6.2-д дурдсан боловч онцгой нөхцөлийн үед угтагсад болон гашуудагсадтай ажиллах, зохицуулах нь чухал бөгөөд маш анхааралтайгаар төлөвлөгдсөн байна. Угтагсад болон гашуудагсад нь ослын нөлөөгөөр сэтгэл санааны хямралд орсон байх магадлалтай тул анхааралтай зохицуулна. Мөн агаарын хөлгийн осолд өртсөн зорчигчийн талаар чухал тодорхойлолт, мэдээллийг өгөх боломжтой юм. Ийм мэдээлэл нь шууд асуулт болон маягт бөглөх аргаар ихэвчлэн олддог.

#### Е.1.2 Аюулгүйн хамгаалалт болон зориулалтын талбай

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь терминалын дотор аль нэг хэсэгт нь угтагсад болон гашуудагсдаас асуулга, уулзалт хийх боломжтой тусгайлсан аюулгүй өрөөг бэлтгэх үүрэгтэй (уулзалтын өрөө, хурлын заал, хүндэт зочны танхим).

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч дээрх байршлыг бэлтгэх боломжтой үед, эсхүл угтагсад болон гашуудагсдыг олон нийтээс тусгаарлах үүргийг аль байгууллага нь хариуцах вэ гэдгийг АОНТ-нд заасан байна. Энэ байгууллага нь угтагсад болон гашуудагсдыг Цагдаагийн газар, хохирогчдыг хамгаалах төв, Аврах анги, Улаан загалмайн нийгэмлэг, мэргэжилтэнтэй хамтран ажиллах талаар зохицуулалтыг хийнэ.

Дээрх хүмүүст шаардлагатай бол холбооны хэрэгсэл, зууш, ундаа зэргээр хангахаас гадна эмнэлгийн туслалцаа үзүүлэхэд анхаарал тавих шаардлагатай.

Тусгаарлах өрөө нь өмгөөлөгч болон зөвлөгөө өгөх хүмүүстэй уулзах, хувийн ярилцлага хийх тусдаа өрөөнд шууд нэвтрэх боломжтой байна. Энэ нь олон нийт болон хэвлэл мэдээллийн байгууллагын сонирхлоос хамгаалагдсан болон ослын талбай шууд харагдах боломжийг хаасан байна.

#### Е.1.3 Мэдээлэлд нэвтрэх

Энэ хүмүүсийг цаг тутамд бодит мэдээллээр хангах нь маш чухал юм. Угтагсад болон гашуудагсад аливаа мэдээллийг олон нийт, хэвлэл мэдээлэл, бусад холбооны хэрэгслээс түрүүлж авах шаардлагатай. Телевизийн дэлгэцээр гарах мэдээллийг нисэх буудал болон нисэх буудлын түрээслэгч нар дотооддоо зөвшилцөж мэдээлэгдэхээс өмнө зохицуулалт хийсэн байх ёстой ба энэ нь тэдний хариуцлагын асуудал бөгөөд нөхцөл байдал өөрчлөгдөх бүрд шүүмжлэгдэх болно.

Гэсэн ч угтагсад болон гашуудагсад нь хувийн гар утас болон компьютерээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нэвтрэх боломжтой гэдгийг анхаарах хэрэгтэй.



#### **E.1.4 Жижиг үйл ажиллагаа эрхлэгчид**

Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн хороо нь АОНТ-ний арга хэмжээг гүйцэтгэх боломжтой байнгын цөөн ажилтантай цөөн тооны агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчдэд анхаарал хандуулах ёстой. Ялангуяа хэвлэл мэдээллийнхэн, хамаатан садан нь нисэх буудал дээр ирсэн үед аэродромын үйл ажиллагаа эрхлэгч, цагдаа, бусад томилогдсон төлөөлөгч нь агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг төлөөлж үйл ажиллагааг явуулах шаардлага гардаг.

#### **E.2 Терминалын зохион байгуулалт**

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь АОНТ-ний нэг хэсгийн дагуу терминалын үйл ажиллагааг зохион байгуулах асуудлыг анхаарна. Үүнд аэродром дээр болон түүний орчимд тохиолдсон осол, өөр аэродромд, эсхүл алслагдсан байршилд гарсан осол нь терминалын үйл ажиллагаанд нөлөөлөх магадлалтай бол холбогдох зохицуулалтыг агуулсан байна.

Нислэгийн мэдээллийн дэлгэцэн дээр гарч буй мэдээлэл, эсхүл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өгч буй мэдээлэлийг анхааралтай тэмдэглэнэ. Дараах зүйлсийг анхаарах:

- Нислэгийн бүс болон агаарын тээвэрлэгчийн оффист нэвтрэхийг хэрхэн хязгаарлах. Эдгээр нь онцгой нөхцөлийн үед хүмүүсийн хамгийн ихээр нэвтрэхийг хүсдэг байршил юм.
- Шаардлагатай үед авах нийтийн бүсийн хяналтын арга хэмжээ, хувийн аюулгүйн хамгаалалтын алба, нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын алба, эсхүл тодорхой бүсийг хамгаалалтанд авах нэмэлт нөөц.
- Лавлах төвд ямар мэдээлэл боломжтой эсэх болон хэрхэн холбогдох
- Хүнсний дэлгүүр нь нээлттэй байх, нэмэлт катерингийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоо тогтоосон байх.
- Аэродром хаалттай үед буюу үйлчилгээний бус цагаар осол гарсан тохиолдолд онцгой нөхцөлийн төлөвлөлт болон терминалын зохицуулалтад нөлөө үзүүлнэ гэдгийг тооцох.
- Ослын нөхцөл дуустал ойр байрлахыг хүссэн хамаатан садан, найз нөхөд, дэмжлэг үзүүлэх байгууллага, нисэх буудлын ажилтан, хэвлэл мэдээлэл зэргийг байрлуулах томоохон зочид буудал, амралт, цэнгээний газар г.м нөөц байршил.

#### **E.3 Ослын талбай - нотлох баримтыг хамгаалах**

*ИНД - 12*

##### **E.3.1 Нотлох баримтыг хамгаалах**

Агаарын хөлгийн ослын дараа холбогдох агаарын хөлгийн үйлдэгдэл, бүрдэл, бусад биет зүйлийг зайлуулахаас өмнө ослыг мөрдөн шалгах ажиллагаа явагдана. Мөрдлөгийн байгууллагад ослын талбар дээрх нотлох баримтыг хамгаалалтанд авах нь чухал бөгөөд онцгой нөхцөлийн хариу арга хэмжээний үе шатанд ослын талбай аль болох бага талхлагдсан байна.

Иргэний нисэхийн дүрэм 12, Дэд бүлэг Ц - Агаарын хөлөг болон түүний эд ангиуд, бичлэгийг хамгаалах - агаарын хөлгийн осол тохиолдсон талбайн нотлох баримтыг хамгаалах шаардлагыг дурдсан байдаг.

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь дүрмийн энэхүү шаардлагыг ойлгосон, хэрэгжүүлэх үйл ажилаагааны процедуртай байх нь чухал юм.

Нэмэлт гарын авлага нь ИНЕГ-ын номын санд болон <http://mcaa.gov.mn> цахим хуудсанд байрлана.

### **Е.3.2 Мөрдөх ажиллагаа болон сүйрлийн үлдэгдлийг цэвэрлэх**

Дараах 3 байгууллага нь агаарын хөлгийн ослын үед шинжлэн шалгах үйл ажиллагаа явуулах эрхтэй болно:

- Зам Тээврийн Яам
- Иргэний Нисэхийн Ерөнхий Газар
- Цагдаагийн Газар

Дээрх шинжлэн шалгах ажиллагаанд оролцсон аль ч байгууллага сүйрлийн үлдэгдлийг цэвэрлэх, зайлуулах боломжтой.

Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь АОНТ-нд заасны дагуу осолдсон агаарын хөлгийг зайлуулах, эсхүл аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй зөвшилцөх үүрэгтэй.

### **Е.3.3 Сүйрэл**

Цагдаагийн газар нь амь үрэгдэгсдийн шинжилгээний ажлыг хариуцна. Цогцос болон биеийн хэсгийг осолд нэрвэгдсэн хүмүүсийг таних ажиллагаанд хэрэглэх болон цагдаагийн газрын зөвшөөрөлгүйгээр зөөвөрлөх ёсгүй.

### **Е.3.4 Хөнгөн агаарын хөлгийн осол**

Ямар нэгэн амь эрсдэл болон ноцтой гэмтэл бэртэлгүй хөнгөн агаарын хөлгийн ослын хувьд аэродромын болон агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь ослын үлдэгдлийг зайлуулах зөвшөөрлийг ИНЕГ-аас албан ёсоор авна.

Хэрэв аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь ИНЕГ-ын байцаагч нарыг ирэхээс өмнө үзлэг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан бол ослын үлдэгдэл зайлуулах болон хэвийн үйл ажиллагааг түргэсгэж болно.

Үүнийг хийхэд аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь ИНЕГ-ын өмнөөс үзлэгийн ажлыг эхлүүлэх, гүйцэтгэхдээ ИНЕГ-аас гаргасан зөвшөөрөл болон, зааврыг бүрэн судалсан байна.

Ослын болон нөхцөл байдлын хүндрэлээс шалтгаалан ИНЕГ урьдчилан зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд зарим зөвшөөрөл нь хэрэглэх боломжгүй байдаг:

- Ослын үед анхан шатны үзлэг хийх сургалтанд суусан ажилтантай бол
- Нотлох баримтыг цуглуулах, фото зураг авах, эд мөрийн баримтын байршлыг тэмдэглэх, талбарын ноорог зураг, тодорхойлох тэмдэглэл болон ИНЕГ-аас шаарддаг бусад ажиллагаа.

## **Е.4 Хэвийн үйл ажиллагаанд эргэж орох - сэргээх үе шат**

АОНТ-ний нэг сэдэв бол Аэродромын онцгой нөхцөлөөс байдлаас шалтгаалсан агаарын хөлгийн үйл ажиллагаанд саад учруулах зүйлсийг багасгах юм. Аэродром дээр тохиолдсон агаарын хөлгийн ослын үед аэродромыг түр хугацаагаар хаах шаардлага үүсдэг.

АОНТ нь аэродромыг аюулгүй статустай, үр ашигтай, зохион байгуулалттай, бүрэн хэмжээний үйл ажиллагаатай ашиглалтанд эргэж оруулах сэргээх үе шатыг багтаасан байна.

Онцгой нөхцөл байдлаас шалтгаалаад агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагааг тодорхой үе шат, хязгаарлалттайгаар сэргээж болох бөгөөд энэ нь ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хэвийн ажиллагаанд орох хүртэл үргэлжилнэ.

Агаарын хөлөг нислэгийн хязгаарлалтад орох гэдэг нь онцгой нөхцөл, эсхүл,сэргээх ажиллагаанд өртөөгүй аэродромын хөдөлгөөний бүсийг ашиглан нислэгийн үйлдвэрлэл эхлүүлэх ажлыг хэлнэ.

Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь аэродромыг хэвийн үйл ажиллагаанд эргэж оруулахдаа дараах асуудлыг анхаарна:

- Барилга байгууламж нь ажиллагаатай эсэхийг тогтоох, эвдрэл гэмтлийн үнэлгээ хийх.
- Хөдөлгөөний бүсэд гадны хаягдал биет бий эсэх үзлэгт онцгой анхаарах. Хучилтгүй /шороон/ ХБЗ болон явгалах зам нь бусад агаарын хөлөгт гэмтэл учруулж болохуйц гадаргын хонхор, гүдгэр байгаа эсэхийг нягтлах. Аэродромын ХБЗ болон явгалах замын орчмын хөрсний гадарга засвар, шинэчлэл хийх шаардлагатай бол бусад агаарын хөлөгт анхааруулах үүднээс тухайн бүсэд анхааруулах тэмдэгт байрлуулж нислэгийн үйл ажиллагааг эхлүүлэх боломжтой бөгөөд дараа нь засварлах.
- Саад тотгор, эвдрэл гэмтлээс шалтгаалаад аюултай бүсийг хааж тэмдэгжүүлнэ. Үүнд сэргээх ажил хийгдэж буй бүс болон ашиглаж буй тээврийн хэрэгслийн явах зам маршрутын хэсэг мөн орсон байна.
- Сэргээх ажиллагаанд ашиглаж буй төхөөрөмж болон хөдлөх чадваргүй болсон агаарын хөлөг нь саадыг хязгаарлах хавтгайг зөрчиж буй эсэх, мөн холбоо навигацын тоног төхөөрөмж болон ойртолт үйлдэж буй агаарын хөлгийн ил хараанд нөлөөлөх эсэхийг анхаарах. Хэрэв саадын хязгаарлах хавтгайд нэвтэрсэн бол хөөрч бүүх зурвасны ашигтай уртын багасгасан хэмжээг тооцож нислэгт ашиглах бөгөөд шаардлагатай аюулгүйн зайг хангасан байна.
- Нислэгийн үйл ажиллагааг сэргээхэд аврах гал унтраах чадвар, боломжийг дахин үнэлэх хэрэв шаардлагатай бол NOTAM мэдээ зарлах.
- Онцгой нөхцөл байдлаас шалтгаалж аэродромыг хаасан ямар нэгэн NOTAM мэдээг цуцлах. Нислэгийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй болсон бүсийг хаасан тухай, эсхүл ХБЗ-ны ашигтай уртын багасгасан хэмжээг өөрчилсөн болон шинээр ашиглах тухай, онцгой нөхцөлөөс болоод агаарын хөлгийн хөдөлгөөн хязгаарлагдсаныг NOTAM-ыг шинээр зарлана.

## **E.5 Бодит онцгой нөхцөлийн дараах тайлан**

*ИНД-139.109(3)*

АОНТ-г бүхэлд нь болон хэсэгчлэн идэвхижүүлэх онцгой нөхцөлийн дараах тайланг заавал гаргана. Онцгой нөхцөлийн үе шат дуусмагц томилогдсон эрх бүхий ажилтан нөхцөл байдлын талаар эргэж тайлан тавих нь зохимжтой байдаг. Энэ нь үүссэн онцгой нөхцөл хүндэрсэн байдлаас мөн хамаардаг бөгөөд Аэродромын онцгой байдлын албадын нэгдсэн үр дүнгийн тайлангийн хурлыг зохион байгуулах нь холбогдох албад тус тусдаа хийснээс илүү үр дүнтэй байдаг.

Үр дүнгийн тайлангийн хурлын хуваарийг хойшлуулж гаргах нь Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөлтийн хорооны бүх гишүүнд оролцох боломж олгодог.

## **Е.6 АОНТ-ний тогтмол хяналт**

### *ИНД-139.101*

ИНД нь аэродромын гэрчилгээ эзэмшигчийг өөрийн АОНТ-ийг /Ерөнхий зааврын нэг бүрдэл/ тогтмол шинэчилж байх, онцгой нөхцөлийн бодит байдал болон дасгал сургуулилтаар нягталж, баталгаажуулж байхыг шаарддаг бөгөөд, бүх ажилтны холбогдох утасны дугаар болон түгээгдсэн хуудсыг хамгийн багадаа жилд нэг удаа шинэчлэж байх ёстой.

Бусад Аэродромын онцгой нөхцөлийн үед авах үр дүнтэй арга хэмжээ, шинэлэг санаачилгыг судлах нь АОНТ-г сайжруулах дараагийн боломж болдог. Бусад аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй холбоо тогтоох, тэдгээрийн онцгой нөхцөлийн сургуулилт болон үр дүнгийн тайлангийн хуралд оролцох боломжийг ашиглах нь маш үр дүнтэй байдаг.

Онцгой нөхцөлийн удирдлага, эсхүл, агаарын хөлгийн осол нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчдэд бусдаас түршлага судлах боломж олгохоос гадна өөрсдийн АОНТ-нд байгаа ижил төстэй, давуу болон сул талыг олж харах боломжийг бүрдүүлдэг.

## Хавсралт F - Холбогдох мэдээлэл

### F.1 Баримт бичиг

#### *ICAO*

Annex 14 - Vol I -Аэродромын төлөвлөлт болон үйл ажиллагаа

Дос 9137-Нисэх буудлын үйлчилгээний заавар, Бүлэг 7-Аэродромын онцгой нөхцөлийн төлөвлөгөө, Дос 9683 -Хүний хүчин зүйлсийн сургалтын заавар

#### *ИНЕГ*

ИНД-12, Бүлэг С-Агаарын хөлөг түүний эд зүйл, бүртгэлийг хамгаалах, ИНД-139 – Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт